**ЭДИЙН ЗАСАГ,**
**ХӨГЖЛИЙН ЯАМ**

# ТАНИЛЦУУЛГА

*Хяналт-шинжилгээ,*
*үнэлгээ хийсэн тухай*

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн "Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай" А/269 дугаар тушаалаар батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг танилцуулж байна.

“Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 24 зорилтын хүрээнд, 142 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт арга хэмжээнээс “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 101 арга хэмжээ, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувийн хэрэгжилттэй 34 арга хэмжээ, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ байна. Нийт дундаж үнэлгээгээр 96.5 хувийн хэрэгжилттэй байна. Тайланг хавсаргав. /хавсралт 1/

## “Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн үнэлгээ

*Хүснэгт 1 (2024 оны жилийн эцсийн байдлаар арга хэмжээний хэрэгжилт)*

| дд | Чиг үүрэг | Арга хэмжээ | Хэрэгжилт | | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | |
| 1 | Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг | 89 | 59 | 24 | 6 | - | - | 97.5 |
| 2 | Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг | 53 | 42 | 10 | 1 | - | - | 95.3 |
| | Нийт | 142 | 117 | 34 | 7 | - | - | 96.5 |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ГАЗАР

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Эдийн засаг, хөгжлийн яам

# 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /ХАВСРАЛТ 1/

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | ХШҮ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | |
| 3.1. | Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг хангаж боловсруулах, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлтийг хийх, хүн амын өсөлтийг дэмжих, хүний | - | - | - | - | 1.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийг боловсруулах ажлын хүрээнд Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Байгаль орчны зорилтот хөтөлбөр, Засаглалын зорилтот хөтөлбөр, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийн төслүүдийг сайжруулж, эхний хувилбарыг боловсруулж ажилласан. 2.Хуульд заасны дагуу "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулж, мөн Засгийн газрын 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы 08 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. 3."Монгол Улсын хөгжлийн | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжлийг хангах, нэгдсэн бодлогыг тодорхойлно. | | | | | 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлуулав. | | |
| 3.1.1 | Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан төслийн эхний хувилбарыг боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан бодлогын баримт бичгийн тоо | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг баталсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хөгжлийн 6 зорилтот хөтөлбөрийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан байна. /Нийт 6 бодлогын баримт бичиг/ | Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийг боловсруулах ажлын хүрээнд Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Байгаль орчны зорилтот хөтөлбөр, Засаглалын зорилтот хөтөлбөр, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийн төслүүдийг сайжруулж, эхний хувилбарыг боловсруулж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. | 100% | 100% |
| 3.1.2 | "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан төлөвлөлтийн баримт бичгийн тоо | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" батлагдсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. /Нийт 1 | Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад "Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна." гэж, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Засгийн газар Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон, эсхүл хуульд заасан хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, ...хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлнэ." гэж, Хөгжлийн бодлого, | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөлтийн баримт бичиг/ | төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулсан бөгөөд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн 4 бодлогын чиглэлийн хүрээнд 16 зорилго, 62 зорилт, түүнийг хэрэгжүүлэх 593 үйл ажиллагааг тусгалаа. Хуульд заасны дагуу "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулж, мөн Засгийн газрын 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы 08 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.<br>Хүрсэн түвшин: Хуульд заасны дагуу "Засгийн газрын 2024-2028 оны үйл | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулж, мөн Засгийн газрын 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы 08 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. | | |
| 3.1.3 | Богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг буюу "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан төлөвлөлтийн баримт бичгийн тоо | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолын хавсралтаар "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-г баталсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. /Нийт 1 төлөвлөлтийн баримт бичиг/ | Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад "Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна." гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэгт "...4.1.13-д заасан баримт бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан батлах;" гэж тус тус заасны дагуу "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. Хамтарсан Засгийн газрын "Хурдтай хөгжлийн төлөөх зориг" гэрээг удирдлага болгон "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-г Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил, Хүний хөгжил, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын гэсэн 4 үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд "Урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурийг бэхжүүлэх" зорилгыг тодорхойлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын 14 мега төсөл, тогтвортой | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийг хурдасгах 149 төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, салбарын реформуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд нийт 314 төсөл, арга хэмжээг 19.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгалаа. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 5.2 их наяд төгрөг, гадаадын зээл, тусламжаар 4.2 их наяд төгрөг, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 4.1 их наяд төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4.1 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээр 1.5 их наяд төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр тусгасан. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлууллаа.<br>Хүрсэн түвшин: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлууллаа. | | |
| 3.1.4 | "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан төлөвлөлтийн баримт бичгийн тоо | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолыг үндэслэн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна. | | | тогтоолын хавсралтаар "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" батлагдсан. | үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна. /Нийт 1 төлөвлөлтийн баримт бичиг/ | хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалд үндэслэн нэгтгэн боловсруулла. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд яамд, байгууллагуудаас нийт 1,592 төсөл, арга хэмжээний санал ирүүлснээс 203.9 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 1,511 төсөл, арга хэмжээг тусган ажиллаж байна. Үүнээс 2025 онд 40.7 их наяд төгрөг, 2026 онд 53.5 их наяд төгрөг, 2027 онд 57.6 их наяд төгрөг, 2028 онд 52.1 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна.<br>Хүрсэн түвшин: Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | | |
| 3.2. - | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, | - | - | - | - | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Тухайлбал, -Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал, зөвлөмж өгч ажиллав. -Аймгуудын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд санал өгч ажиллав. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | арга зүйн зөвлөгөө өгнө. | | | | | | | |
| 3.2.1 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулах журмын төслийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Холбогдох журмын төслийг боловсруулсан байна. /Нийт 1 журмын төсөл/ | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг боловсруулах ажлын хүрээнд "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар аргачлалын төсөл болон "Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах аргачлал", "Монгол улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын төслийг сайжруулан боловсруулж байна. Журмын төсөлд яамны зохион байгуулалтын нэгжүүдээс саналыг авч нэгтгэн, сайжруулж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар аргачлалын төсөл болон "Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах аргачлал", "Монгол улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын төслийг сайжруулан боловсруулсан. | 100% | 90% |
| 3.2.2 | Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагаар | Үйл ажиллагааны зардлаар | Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагаар удирдлага, | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагаар | Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь "урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурийг бэхжүүлэх" бөгөөд "Эдийн засаг", "Бүсчилсэн хөгжил", "Хүний хөгжил", "Хүний эрхийг дээдэлсэн засаглал" гэсэн тэргүүлэх чиглэлийн | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлага, зохион байгуулалтаар хангана. | | зохион байгуулалтаар хангасан байх, хувиар | | удирдлага, зохион байгуулалтаар хангасан байна. | хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудлуудад үндэслэн тодорхойлж, шаардлагатай салбарын реформыг шуурхай эхлүүлж, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхийг зорьсон. Эдийн засгийн бодлогын хүрээнд урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг 2025 онд бүрэн эхлүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, зах зээл дэх төрийн оролцоог хялбарчлах, салбаруудад бодлогын цогц реформыг хийх шинэчлэлийн ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан. Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, иргэн бүр тэгш эрхтэйгээр нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах, орлого олох, хөгжих боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн гэр бүл, хүүхэд, эхчүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан, залуучуудын онцлогт нийцүүлсэн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан.<br>Хүрсэн түвшин: Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан. | | |
| 3.2.3 | Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, | Үйл ажиллагааны зардлаар | Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг | Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "Хүний хөгжлийн бодлого" хоёрдугаар бүлэгт "Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хөгжих, суралцах, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, чинээлэг, баялагтаа эзэн, | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангана. | | зохион байгуулалтаар хангасан байх, хувиар | | удирдлага, зохион байгуулалтаар хангасан байна. | эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ" зорилгыг тусгаж, гэр бүл, хүүхэд, эхчүүд, эмэгтэйчүүд зэрэг бүлгүүдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн баталгаа, эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 134 зорилт, арга хэмжээг төлөвлөн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлуулсан. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гуравдугаар бүлэгт Хүний хөгжлийн бодлогыг тусган өвчлөл, нас баралтыг бууруулах, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зэргээр хөтөлбөрийн 15 үр дүн, 58 төсөл, арга хэмжээг тусган, Монгол Улсын Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Хүрсэн түвшин: Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан. | | |
| 3.2.4 | Монгол Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг | Үйл ажиллагааны зардлаар | 2024 оны улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн байх | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгнө. | | | Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2022 онд зөвшөөрөл өгсөн. | Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, зөвшөөрөл өгсөн байна. | асуудлаар 2024 оны 09 дүгээр сард зөвшөөрөл өгсөн.<br>Хүрсэн түвшин: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, зөвшөөрөл өгсөн. | | |
| 3.2.5 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байх, хувиар | Хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг тухай бүр зохион байгуулсан. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна. /100 хувь/ | Дараах хэлэлцүүлэг, семинарыг зохион байгуулав. Үүнд: 1. "Тогтвортой хөгжлийн зорилго" Үндэсний хэлэлцүүлгийг Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний байгууллагатай хамтран 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулав. НҮБ-ын "Ирээдүйн асуудлаарх дээд түвшний чуулга уулзалт"-д оролцох Монгол Улсын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, залуучууд болон эрдэмтэн судлаачдын төлөөлөл оролцож, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын хурдасгуур, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр санал, бодлоо солилцож, нэгдсэн санал, зөвлөмжийг НҮБ-ын "Ирээдүйн асуудлаарх дээд түвшний | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чуулга уулзалт"-д танилцуулах ач холбогдолтой байв. 2. УИХ-ын харьяа байгууллагууд болон Хууль зүй, дотоод хэргийн яамны албан хаагчдад "Үр дүнд суурилсан арга зүйгээр бодлогын баримт бичгийг төлөвлөх нь" сэдэвт илтгэл тавьж, хэлэлцүүлэгт оролцов. 3.Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Монгол Германы хамтарсан Ашигт малтмал технологийн их сургууль болон Бүсчилсэн хөгжлийн хүрээлэнгээс хамтран 2024 оны 11 дүгээр сарын 08-ний өдөр зохион байгуулсан "Тогтвортой ирээдүй: Налайх-Их сургуулийн ногоон хот" сэдэвт эрдэм шинжилгээний хуралд "Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, баримталж буй зарчим" сэдэвт илтгэл хэлэлцүүлж, холбогдох албаны хүмүүстэй санал солилцов.<br>Хүрсэн түвшин: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | | |
| 3.2.6 | Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгнө. | Үйл ажиллагааны зардлаар | Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн байх, хувиар | Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал | Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал, зөвлөмж өгч ажиллав. Мөн аймгуудын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд санал өгч ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгч ажиллав. | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үзүүлж, санал өгсөн. | өгсөн байна. /100 хувь/ | | | |
| 3.2.7 | Эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз суурийг бэхжүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байх. | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байна. | “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил, Хүний хөгжил, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын гэсэн 4 үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын 14 мега төсөл, тогтвортой хөгжлийг хурдасгах 149 төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, салбарын реформуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эдийн засгийн бодлогын хүрээнд урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг 2025 онд багтааж бүрэн эхлүүлэх, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, зах зээл дэх төрийн оролцоог хялбарчлах, салбаруудад бодлогын цогц реформыг хийх ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эрчим хүч, зам тээвэр, хөдөө аж ахуй, банк санхүүгийн салбарт бодлогын цогц шинэчлэл, либералчлалыг хэрэгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Уул уурхайн салбарт тусгай зөвшөөрлүүдийг ил тод болгож, Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалдаг бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, биржийн тогтолцоог бэхжүүлнэ. Мөн шинжлэх ухаан, технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулах бодлогыг хэрэгжүүлнэ. Дижитал эдийн засаг, ногоон эдийн засгийг бодитой нутагшуулж, Старт-Ап, инновацыг дэмжих бодлого, хөшүүргийг тодорхойлж хэрэгжүүлэх юм. | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлж ажиллав. | | |
| 3.2.8 | Судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулсан байх | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн байна. | Судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Үндэсний хөгжлийн хүрээлэнг байгуулж, тус хүрээлэн нь ажиллагааг эхлүүлээд байна. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Б/23 дугаар тушаалаар Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирлаар Г.Дэнзэнг томилсон. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Хүрээлэнгийн бүтцийг 5 нэгжтэй, 35-аас илүүгүй орон тоотой байхаар баталсан. Хүрээлэнгийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад шинээр томилогдсон захиралд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: Судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Үндэсний хөгжлийн хүрээлэнг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. | 100% | 100% |
| 3.2.9 | Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулж, нэвтрүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Судалгааны тоо /Тоо/ | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Олон Улсын хөгжлийн туршлага, чиг хандлагын талаар судалгаа хийсэн байна. | Дэлхийн улс орнуудын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах ажлын хүрээнд улс орнуудын хөгжлийн чиг хандлага, туршлагыг судалж байна. Тухайлбал, БНСУ, БНХАУ, Киргиз, Казахстан, ОХУ болон Турк Улсын хөгжлийн чиг хандлага, туршлагыг судаллаа. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/96 дугаар тушаалаар | 100% | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | /Нийт 1 судалгаа/ | “Дэлхийн улс орнуудын туршлага, хөгжлийн чиг хандлагыг судалж, баримт нотолгоонд суурилсан, дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах” судалгааг хийж гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан.<br>Хүрсэн түвшин: Олон Улсын хөгжлийн туршлага, чиг хандлагын талаар судалгаа хийсэн. | | |
| 3.2.10 | Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судлах, нутагшуулах, хөгжүүлэлтийг дэмжинэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судалсан байх | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судалсан байна. | Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологийг судалж байна. Хөгжлийн нэгдсэн бодлог, төлөвлөлтийн газар нь хөгжлийн бодлого боловсруулах үйл явцыг үр дүнтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй болгох зорилгоор технологи нутагшуулах, хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд хиймэл оюун ухааныг ашиглан бодлогын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхойлох судалгаа хийж байгаа бөгөөд энэхүү ажлын хүрээнд холбогдох мэргэжлийн чиг үүрэг бүхий 3 компанитай уулзан харилцан үр дүнд хүрэхээр ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологийг судалсан. | 100% | 70% |
| 3.2.11 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, мэдээллийг | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан | Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар нь Монгол улсын хөгжлийн төлөвлөгөөг бодлогын хэрэгжилттэй нь уялдуулах, яамд, байгууллагуудын уялдааг хангах зорилгоор нийтийн мэдээллийн санг байгуулахаар ажиллаж байна. | 100% | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эргэлтэд оруулна. | | | | байгуулах асуудлыг судалсан байна. | Хүрсэн түвшин: Улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах асуудлыг судалсан. | | |
| 3.3. | Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна. | - | - | - | - | Монгол Улсын 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн төслийг УИХ-ын чуулган, холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлсэн ба 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-ын чуулганаар тус бодлогын баримт бичгийг батлаад байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлсэн. Тухайлбал, эдийн засгийн өсөлтийг 2025 онд 8.0 хувь, 2026-2027 онд 6.5 хувь, инфляцыг 2025 онд 6 хувь, 2026 онд 4 хувь, 2027 онд 3 хувь байхаар төсөөлсөн.<br>Хавсралт: 2 файл | 100% | 100% |
| 3.3.1 | Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн | Үйл ажиллагааны зардаар | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоол "Монгол Улсын хөгжлийн | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Монгол Улсын 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж | Монгол Улсын 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Тус бодлогын баримт бичгийн төслийг УИХ-ын чуулган, холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлсэн ба УИХ-ын 2024 оны 10 | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана. | | | 2024 оны төлөвлөгөө" батлуулсан. | танилцуулсан байна. /1 танилцуулга / | дугаар сарын 18-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлаад байна.<br>Хүрсэн түвшин: Монгол Улсын 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулсан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.3.2 | Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг гүйцэтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Эдийн засгийн 2025 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/ | Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан. Тус бодлогын баримт бичгийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн төслийг УИХ-ын чуулган, холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлж 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлуулаад байна.<br>Хүрсэн түвшин: Эдийн засгийн 2025 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэсэн.<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 3.3.3 | Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн | Үйл ажиллагааны зардлаар | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2025 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн ба УИХ-ын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар баталсан. Монгол Улсын ерөнхийлөгчийн хориг тавьсантай холбоотойгоор макро эдийн засгийн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | | | | боловсруулсан байна. /1 танилцуулга/ | үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг дахин боловсруулж Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусган 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байна.<br>Хүрсэн түвшин: Макро эдийн засгийн нөхцөл байдал, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2025 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.4. | Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно. | - | - | - | - | Монгол Улсын 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн төслийг УИХ-ын чуулган, холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлж 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлуулаад байна. Мөн Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж тус бодлогын баримт бичигт тусгасан болно.<br>Хавсралт: 1 файл | 100% | 90% |
| 3.4.1 | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro | Үйл ажиллагааны | Дүн шинжилгээний тоо | Өмнөх онуудын эдийн засгийн | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2024 оны | Макро эдийн засгийн нөхцөл байдлын улирал тутмын танилцуулгад төсвийн чиглэлээр дүн шинжилгээ хийж, англи, монгол хэл дээр танилцуулгыг бэлтгэн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, танилцуулна. | зардлаар | | нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. | түвшинд дүн шинжилгээ хийж танилцуулсан байна. /хийсэн тухай бүрийн танилцуулга/ | хэвлэн нийтлүүлж удирдлагуудыг мэдээллээр ханган ажиллав. Мөн хэвлэн нийтлэсэн танилцуулгыг УИХ-ын гишүүд, салбар яамд, олон улсын байгууллагуудад хүргүүлж яамны цахим хуудсаар олон нийтэд хүргэн ажиллав.<br>Хүрсэн түвшин: Макро эдийн засгийн 2024 оны 1-3 дугаар улирлын төлөв байдалд дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.4.2 | Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана. | Үйл ажиллагааны зардлаар | Хөгжүүлсэн загварын тоо | Мэдээллийн дата баазыг бүрдүүлж, туршилт тооцооллуудыг гүйцэтгэсэн. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Загвар хөгжүүлсэн байна /1 загвар/ | Макро эдийн засгийн бодлогын газраас богино, дунд хугацааны загварыг хөгжүүлж тооцоо, төсөөлөлд ашиглаж байна. Тухайлбал: 1.GIZ байгууллагаас зохион байгуулсан уур амьсгалын өөрчлөлтийн загвар хөгжүүлэх сургалтад хамрагдаж загварыг өөрийн орны онцлогт тохирсон загвар бий болгон эдийн засгийн тооцоо, төсөөлөлд ашиглаж байна. 2.ОУВС-ийн Казакстан дах CCAMTAC төвөөс Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс 18-ны өдрийг хүртэл FPP загварыг хөгжүүлэх сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан. Макро эдийн засгийн дүн шинжилгээ, төсөөллийг уг FPP загвар болон MS Excel-д суурилсан tool ашиглан хийж, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн танилцуулгад тусгасан. 3. Нөөц, ашиглалтыг хүснэгтийг ашиглан салбар хоорондын тэнцлийг байгуулж, салбаруудын үржүүлэгчийг ашиглан | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсвийн хөрөнгө оруулалтын импортод нөлөөлөх тооцож төсөөлөл хийхэд ашиглаж байна. 4. "МУ-ын эдийн засагт шууд татварын хувь хэмжээг 1 хувиар бууруулахад үзүүлэх нөлөөллийг Тооцоолох Ерөнхий Тэнцвэрийн Загвар (CGE Model) хөгжүүлж тооцооллыг хийсэн. Суурь тоон өгөгдөл болох 2018 оны Нийгмийн тооцооллын матриц дахь өрхүүдийн орлогыг ӨНЭЗС-аас тооцон 5 бүлэгт хуваж задлан шинжилсэн. 5. БНСУ, Евроазийн эдийн засгийн холбоо, БНХАУ-тай байгуулах Чөлөөт худалдааны хэлэлцээр болон Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулахад шаардлагатай эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг олон улсын худалдааны GTAP загвар ашиглан тооцож үр дүнг боловсруулсан. 6. Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлэх Олон улсын валютын сангийн COVID stress test, PFRAM зэрэг эрсдэлийн загвар болон төсөв санхүүгийн Financial programing and policy (FPP) загваруудыг өөрийн орны онцлогт тохируулан ажиллуулж, хөгжүүлэх Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад тооцоо, төсөөлөлд ашиглахаар хөгжүүлэлтийг хийн ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: Загварууд хөгжүүлсэн.<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.4.3 | Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн | Үйл ажиллагааны | Мэдээллийн тоо /Тоо/ | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: | Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр мэдээллийн сан үүсгэн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | статистикийн сарын гүйцэтгэлээр мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана. | зардлаар | | | Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/ | танилцуулга бэлтгэн удирдлагыг тухай бүр мэдээллээр хангаж ажиллаж байна. Тухайлбал, тус газраас олон нийтэд нээлттэй мэдээлдэг Макро эдийн засгийн сарын мэдээнд ДНБ, гадаад худалдаа, түүхий эдийн үнийн хандлага, уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөрийн тэнцэл, инфляц, мөнгө санхүү, гадаад эдийн засаг, БНХАУ-ын нүүрсний зах зээл, бизнес регистр, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд суурилсан тооцоо шинжилгээг тусган англи, монгол хэлээр хүргэж байна.<br>Хүрсэн түвшин: Тухай бүр мэдээллээр хангасан<br>Хавсралт: 5 файл | | |
| 3.4.4 | Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн тоо /Тоо/ | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/ | Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, power app аппликэйшний тусламжтайгаар удирдлагыг шуурхай мэдээллээр тухай бүр хангаж байна. Тус мэдээнд, уул уурхайн голлох бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн ханш, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш, экспортын голлох бүтээгдэхүүн (өдрөөр) зэрэг багтсан болно.<br>Хүрсэн түвшин: Тухай бүр мэдээллээр хангасан<br>Хавсралт: 2 файл | 100% | 100% |
| 3.4.5 | Монгол Улсын эдийн засгийн эрсдэлийг тодорхойлж дунд, богино | Үйл ажиллагааны зардлаар | Эдийн засгийн эрсдэлийг тодорхойлсон | Эдийн засгийн болзошгүй эрсдэлийн нөхцөл | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Болзошгүй эрсдэлийн | Монгол Улсын эдийн засгийн эрсдэлийг тодорхойлж Монгол Улсын 2025 оны Төсвийн хүрээн мэдэгдэл, Монгол Улсын 2025 оны төсөв, Монгол Улсын 2025 он хөгжлийн төлөвлөгөөний баримт бичигт | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацааны бодлогын баримт бичиг болон төсвийн тухай хуулийн танилцуулгад тусгана. | | танилцуулгын тоо | байдалд дүн шинжилгээ хийсэн. | судалгааг боловсруулж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан байна. /2 танилцуулга/ | тусгасан. Макро эдийн засагт учир болох эрсдэлийг үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах бодлогын санал, шийдлүүдийг тодорхойлон гаргав. Тухайлбал, Эрчим хүчний тасалдал: Эрчим хүчний хангамж доголдсоноор төсвийн зардал нэмэгдэх, эдийн засгийн салбаруудад үзүүлэх нөлөөллийг тооцоолов. Цаг агаарын хүндрэл (зуд, ган): Байгалийн гамшиг, үүнтэй холбоотой мал аж ахуйн хорогдол болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн бууралтаас үүдэх орлогын алдагдлыг үнэлсэн. Мал амьтны өвчин: Мал аж ахуйн салбар дахь эрсдэл нь экспорт, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөөг тодорхойлон төсөвт учрах зардлыг тооцоолсон. Экспортын түүхий эдийн үнийн хэлбэлзэл: Дэлхийн зах зээл дээрх нүүрс, зэс зэрэг голлох бүтээгдэхүүний үнийн уналтаас үүдэн төсвийн орлогын багасалтад үзүүлэх нөлөөг нарийвчлан шинжилсэн. Геополитикийн тогтворгүй байдал: Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын эрсдэлүүд болон олон улсын зах зээлд гарах хүндрэлээс үүдэн үүсэх төсвийн дарамтыг үнэлсэн. Нийлүүлэлтийн тасалдал: Гадаад болон дотоодын тээвэр, ложистикийн доголдлоос шалтгаалан үүсэх төсвийн зардлын нэмэгдлийг судалсан. Эдгээр эрсдэлүүдийн шинжилгээний үр дүнд төсөвт учирч болзошгүй хүндрэлүүдийг тодорхойлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр бодлогын дараах санал, зөвлөмжүүдийг боловсруулсан. Тухайлбал, төсвийн эрсдэлийн нөөц санг нэмэгдүүлэх, зардлыг оновчтой хуваарилах, экспортын | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түүхий эдээс хамаарах хамаарлыг бууруулах олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон болно.<br>Хүрсэн түвшин: Болзошгүй эрсдэлийн судалгааг боловсруулж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.4.6 | Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт) | Үйл ажиллагааны зардлаар | Тайланд ашигласан тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Улирлын тайланд ашигласан байна. /3 удаа/ | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутмын танилцуулгад гаалийн дата, И-баримтын датаг боловсруулан гадаад худалдааны нөхцөл байдал, борлуулалтын нөхцөл байдалд шинжилгээ хийн тусгасан болно. Тухайлбал, НӨАТ-ын дата баазад суурилж аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын сар, улирлын давтамжтай дата, мэдээллээр мэдээллийн сан үүсгээд байна. Түүнчлэн Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн улирал, жилийн мэдээллээр дата бааз үүсгэсэн. Мөн засаглал, нийгэм, эдийн засаг, хөгжил, дэд бүтцийн 93 олон улсын индексээрх Монгол Улсын үнэлгээ, эрэмбийн цагийн цувааны дата бааз үүсгээд байна. Гааль, И-баримтын датаг сар бүрд тогтмол авч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого, НӨАТ-ын шивсэн баримтын тоонд тооцоо, судалгаа хийж макро эдийн засгийн улирал, сар тутмын танилцуулгад оруулж, удирдлагыг холбогдох мэдээллээр тогтмол хангаж ажиллаж байна. Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран Гааль, И-баримтын датаг тогтмол авч сар, улирлын тайлан, | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулгад дүн шинжилгээ хийн ажиллав.<br>Хүрсэн түвшин: Улирлын тайланд ашигласан.<br>Хавсралт: 4 файл | | |
| 3.4.7 | Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгааг боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Судалгааны тоо | Судалгаанд шаардлагатай тоон мэдээллийг цуглуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгаа боловсруулсан байна. /1 судалгаа/ | Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгааг эдийн засгийн бодит секторын хувьд боловсруулсан. Тус тайлан нь салбаруудын урт хугацааны хандлага, үйлдвэрлэлийн потенциал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зэргээс бүрдсэн. Тухайлбал, тус тайлангаас дараах зөвлөмж гараад байна. -Төрийн оролцоог, хөрөнгө оруулалтыг хумих, төр, хувийн хэвшлэлийн түншлэлийг сайжруулах -Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, ингэхийн тулд ханшийг тогтвортой түвшинд байхыг дэмжих, гадаадын санхүүгийн байгууллагыг авчрах зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, -Боловсруулах салбарын өсөлтийг эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх -Ажилчдын ур чадвар бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилчдыг сургах үйлдвэрлэлийн дадлагын материаллаг баазыг нэмэгдүүлэх.<br>Хүрсэн түвшин: Судалгаа боловсруулсан6<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 3.5. | Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд | - | - | - | - | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулж, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлнэ. | | | | | Тухайлбал, олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр төрийн болон төрийн бус, судалгаа, шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага болон болон иргэдийн төлөөллийг оролцуулсан байдлаар цахим болон танхимын хэлбэрээр зохион байгууллаа. Олон нийтийн хэлэлцүүлэгт 100 гаруй хүн оролцсон бөгөөд нийт 300 гаруй санал цахимаар болон цаасаар ирүүлсэн болно.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.5.1 | Монгол Улсын төсвийн дунд хугацааны эрсдэлийг тодорхойлж тайлан танилцуулга бэлтгэн, удирдлагад танилцуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тайлан боловсруулсан байна. /1 тайлан/ | Төсвийн эрсдэлийн тайланг макро эдийн засгийн дүн шинжилгээнд тулгуурлан боловсруулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр тогтмол хангаж ажилласан. Тайлан боловсруулахдаа төсвийн эрсдэлд нөлөөлж болзошгүй олон хүчин зүйлийн үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах бодлогын санал, шийдлүүдийг тодорхойлон гаргав. Эрчим хүчний тасалдал: Эрчим хүчний хангамж доголдсоноор төсвийн зардал нэмэгдэх, эдийн засгийн салбаруудад үзүүлэх нөлөөллийг тооцоолов. Цаг агаарын хүндрэл (зуд, ган): Байгалийн гамшиг, үүнтэй холбоотой мал аж ахуйн хорогдол болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн бууралтаас үүдэх орлогын алдагдлыг үнэлсэн. Мал амьтны өвчин: Мал аж ахуйн салбар дахь эрсдэл нь экспорт, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөөг тодорхойлон төсөвт учрах зардлыг тооцоолсон. Экспортын түүхий эдийн үнийн хэлбэлзэл: Дэлхийн зах зээл дээрх | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нүүрс, зэс зэрэг голлох бүтээгдэхүүний үнийн уналтаас үүдэн төсвийн орлогын багасалтад үзүүлэх нөлөөг нарийвчлан шинжилсэн. Геополитикийн тогтворгүй байдал: Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын эрсдэлүүд болон олон улсын зах зээлд гарах хүндрэлээс үүдэн үүсэх төсвийн дарамтыг үнэлсэн. Нийлүүлэлтийн тасалдал: Гадаад болон дотоодын тээвэр, логистикийн доголдлоос шалтгаалан үүсэх төсвийн зардлын нэмэгдлийг судалсан. Эдгээр эрсдэлүүдийн шинжилгээний үр дүнд төсөвт учирч болзошгүй хүндрэлүүдийг тодорхойлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр бодлогын дараах санал, зөвлөмжүүдийг боловсруулсан. Тухайлбал, төсвийн эрсдэлийн нөөц санг нэмэгдүүлэх, зардлыг оновчтой хуваарилах, экспортын түүхий эдээс хамаарах хамаарлыг бууруулах олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон болно.<br>Хүрсэн түвшин: Тайлан боловсруулсан<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.5.2 | Эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн тайлан бэлтгэж удирдлагад танилцуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Тайлангийн тоо | Тайланд шаардлагатай судалгааны тоон мэдээллийг цуглуулсан. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Тайлан боловсруулсан байна. /1 тайлан/ | Эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн тайланг зээл, хөдөлмөр, аж ахуйн нэгжийн төлөв байдал, нийцэлд тооцоо, судалгаа хийж боловсруулсан. Тайлангийн голлох үр дүнгээс дурдвал: Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд сайжирч, хөдөлмөрийн зах зээл тэлж буй нь иргэд болон өрхийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийн идэвхжилийг дэмжих гол хүчин зүйл болж байна. Үүний | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үр дүнд хөдөлмөр эрхэлж буй иргэдийн цалин, ахмад настнуудын тэтгэвэр, нийгмийн хамгааллын хүрээнд олгогдож буй тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн нь өрхийн санхүүгийн чадамжийг дээшлүүлж, хэрэглээ өсөхөд зэрэг нөлөө үзүүлж байна. Өрхийн хэрэглээний өсөлт нь эцсийн дүндээ эдийн засгийн дотоодын эрэлт, хэрэглээг тэтгэж, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Мөн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа идэвхжиж, шинээр байгуулагдаж буй аж ахуйн нэгж, бизнесийн тоо өсөх хандлагатай байна. Үүнийг даган иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудын зээлийн өсөлт эрчимжиж, санхүүгийн хүртээмж сайжирч байгаа нь бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлж, эдийн засгийн дотоодын эрэлт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд хөдөлмөр эрхлэлт, өрхийн хэрэглээ, бизнесийн идэвхжил зэрэг эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сайжирч байгаа нь дотоодын эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлж байна.<br>Хүрсэн түвшин: Тайлан боловсруулсан<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.5.3 | Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаар | Үйл ажиллагааны зардлаар | Хэлэлцүүлэг зохион байгуулсан тоо | - | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр төрийн болон төрийн бус, судалгаа, шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулна. | | | | байна. /1 хэлэлцүүлэг/ | байгууллага болон болон иргэдийн төлөөллийг оролцуулсан байдлаар цахим болон танхимын хэлбэрээр зохион байгууллаа. Олон нийтийн хэлэлцүүлэгт 100 гаруй хүн оролцсон бөгөөд нийт 300 гаруй санал цахимаар болон цаасаар ирүүлсэн болно.<br>Хүрсэн түвшин: Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.5.4 | Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2024-2027 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулсан байна. /1 танилцуулга/ | “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай” хуулийн төслийг боловсруулж, Засгийн газар болон УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж 2024.06.05-ны өдөр батлуулсан. Гэвч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах эрх зүйн шаардлага үүссэн. Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг Ерөнхийлөгчийн тавьсан хоригт нийцүүлэн боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн бариад байна. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2024-2027 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулсан.<br><br>Хавсралт: 1 файл | | |
| 3.6. | Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана. | - | - | - | - | Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Бертельсманны шилжилтийн индекс зэрэг олон улсын голлох индексүүдийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг нэгтгэн боловсруулж, эрэмбэ байрыг ахиулах боломжийг судлан, санал бэлтгэж танилцуулгад тусган удирдлагад танилцуулав. Үнэлгээг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмжүүдийг тодорхойлж, хөгжлийн төлөвлөгөө, төсвийн бодлогын баримт бичигт тусгасан. Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадвар, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг хэмжиж буй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн голлох индексүүдийн аргачлал, хэмжиж буй үзүүлэлтүүд, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн бэлтгэж яамны цахим хаяг болон веб хуудаст тогтмол байршуулж байна. Үүний хүрээнд 2024 оны эхний хагаст Өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2024 оны үнэлгээ, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тус яамны веб хуудасны "Эдийн засгийн тойм блог" цэст байршуулав. Түүнчлэн тус газраас | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулж, олон нийтэд нээлттэй байршуулж, бодлогын шийдвэр гаргагч байгууллагуудад тараадаг Макро эдийн засгийн 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1-3 дугаар улирлын тайланд "Олон улсад зарлагдсан индексүүд"-ийн дэд бүлгийг бэлтгэн оруулсан. Тайланд Авлигын төсөөллийн индекс, Ардчиллын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, Бертелсманны Шилжилтийн индекс, Өв уламжлалын сангийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Засаглалын үзүүлэлтүүд, Фрэйзэр институтийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексүүдийн Монгол Улсын үнэлгээ болон олон улсын чиг хандлагад шинжилгээ хийж оруулаад байна.<br>Хавсралт: 5 файл | | |
| 3.6.1 | Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг Өв уламжлалын сангаас гаргадаг "Эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс"-т тулгуурлан судалж шаардлагатай тоо, мэдээллийг цуглуулан сан үүсгэж дүн | Үйл ажиллагааны зардлаар | Өгөгдлийн сангийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Өгөгдлийн сан үүсгэсэн байх /1 файл/ | Өв уламжлалын сангийн "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс"-ийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг цуглуулан нэгтгэж, дүн шинжилгээ хийж дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэн, удирдлагуудад танилцуулж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Өгөгдлийн сан үүсгэсэн.<br>Хавсралт: 3 файл | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ хийнэ. | | | | | | | |
| 3.6.2 | Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр санал боловсруулж танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Танилцуулгын тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/ | Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Бертельсманны шилжилтийн индекс зэрэг олон улсын голлох индексүүдийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг нэгтгэн боловсруулж, эрэмбэ байрыг ахиулах боломжийг судлан, санал бэлтгэж танилцуулгад тусган удирдлагад танилцуулав. Үнэлгээг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмжүүдийг тодорхойлж, хөгжлийн төлөвлөгөө, төсвийн бодлогын баримт бичигт тусгасан.<br>Хүрсэн түвшин: Танилцуулга боловсруулсан<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 3.6.3 | Эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр олон нийтэд үнэн, зөв мэдээлэл хүргэж ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Олон нийтэд хүргэсэн мэдээллийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна. /1 нийтлэл/ | Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадвар, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг хэмжиж буй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн голлох индексүүдийн аргачлал, хэмжиж буй үзүүлэлтүүд, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн бэлтгэж яамны цахим хаяг болон веб хуудаст тогтмол байршуулж байна. Үүний хүрээнд 2024 оны эхний хагаст Өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2024 оны үнэлгээ, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тус яамны веб хуудасны "Эдийн засгийн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тойм блог" цэст байршуулав. Түүнчлэн тус газраас боловсруулж, олон нийтэд нээлттэй байршуулж, бодлогын шийдвэр гаргагч байгууллагуудад тараадаг Макро эдийн засгийн 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1-3 дугаар улирлын тайланд "Олон улсад зарлагдсан индексүүд"-ийн дэд бүлгийг бэлтгэн оруулсан. Тайланд Авлигын төсөөллийн индекс, Ардчиллын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, Бертелсманны Шилжилтийн индекс, Өв уламжлалын сангийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Засаглалын үзүүлэлтүүд, Фрэйзэр институтийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексүүдийн Монгол Улсын үнэлгээ болон олон улсын чиг хандлагад шинжилгээ хийж оруулаад байна.<br>Хүрсэн түвшин: Олон нийтэд мэдээлэл хүргэсэн<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.7. | Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр хууль тогтоомж, урт, дунд хугацааны | - | - | - | - | Уг зорилтын хүрээнд төлөвлөсөн 11 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласан. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулна. | | | | | | | |
| 3.7.1 | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалын хамт батлуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/ | Судалгааны тайлан Үзэл баримтлал боловсруулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: БШУ, ХЗДХ-ийн сайдын хамтарсан шийдвэрээр үзэл баримтлалыг батлуулсан байна. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, тэмдэглэл гаргуулж, УИХ-д хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байна. /Баримт бичиг 2/ | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг эцэслэн боловсруулж, хуулийн үзэл баримтлалыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан шийдвэрээр батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг эцэслэн боловсруулж, хуулийн төсөлд 15 яамдаас санал авч нэгтгэн 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар УИХ-д өргөн мэдүүлэх шийдвэрийг гаргуулж, 05 сарын 16-ны өдрийн хуралдаанаар батлуулсан.<br>Хүрсэн түвшин: - Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал /батлагдсанаар/ - УИХ-ын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар баталсан Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140710245891<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 3.7.2 | Шинжлэх ухааны паркийн | Үйл ажиллаг | Боловсруулсан | Судалгааны тайлан | Эхний хагас жилд: - | Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулна. | ааны зардлаар | баримт бичгийн тоо /Тоо/ | боловсруулсан. | Жилийн эцэст: Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан байна. /Баримт бичиг 2/ | үзэл баримтлалын төслийг эцэслэн боловсруулж, хуулийн үзэл баримтлалыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан шийдвэрээр батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг эцэслэн боловсруулсан.<br>Хүрсэн түвшин: - Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал - Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төсөл<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.7.3 | Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг 2025-2028 онд хөгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/ | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна. /Баримт бичиг 1/ | Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэн яамдаас санал авахаар илгээсэн.<br>Хүрсэн түвшин: Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогын чиглэл<br>Хавсралт: 1 файл | 90% | 90% |
| 3.7.4 | Технологи дамжуулах хөтөлбөрийг боловсруулж, батлуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/ | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Технологи дамжуулах | Технологи дамжуулах хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг тус тус боловсруулсан. | 90% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөтөлбөрийг батлуулан зарим үйл ажиллагааны хэрэгжилтийг эхлүүлсэн байна. | Хүрсэн түвшин: - Технологи дамжуулах хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.7.5 | Шинжлэх ухаан, технологийн төслийн зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журмыг батлуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/ | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны "Журам батлах тухай" А/319 дүгээр тушаал боловсруулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Шинжлэх ухаан, технологийн төслийн зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журмыг шинэчлэн батлуулсан байна. /Баримт бичиг 1/ | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3. дахь заалтын хүрээнд Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлдэг шинжлэх ухаан, технологийн төслүүдийн санхүүжилтэд эзлэх эрдэм шинжилгээний зардлын хэмжээний доод хязгаарыг тогтоон бусад зардлыг төслөөр хийгдэх судалгааны ажлын онцлогоос шалтгаалан хоорондоо уян хатан байдлаар зохицуулагдахаар тусгаж өгсөн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/133 дугаар тушаалаар "Шинжлэх ухаан, технологийн төслийн төсөвт өртгийг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журам"-ыг баталсан.<br>Хүрсэн түвшин: Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/133 дугаар тушаалаар "Шинжлэх ухаан, технологийн төслийн төсөвт өртгийг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журам"<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 3.7.6 | Төсвийн хөрөнгөөр | Үйл ажиллаг | Боловсруулсан | ЗГ-ын 2015 оны 267 | Эхний хагас жилд: - | Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх | 90% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмыг шинэчлэн батлуулна. | ааны зардлаар | баримт бичгийн тоо /Тоо/ | дугаар тогтоол батлуулсан. | Жилийн эцэст: Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. /Баримт бичиг 1/ | ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмын төслийг боловсруулсан.<br>Хүрсэн түвшин: Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмын төсөл | | |
| 3.7.7 | Шинжлэх ухаан, технологийн төслийн санал үнэлгээ өгч, дүгнэлт гаргах аргачлалыг шинэчлэн батлуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/ | БСШУС-ын сайдын 2018 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/696 дугаар тушаал | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Шинжлэх ухаан, технологийн төслийн санал үнэлгээ өгч, дүгнэлт гаргах аргачлалыг шинэчлэн батлуулсан байна./ баримт бичиг 1/ | Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны тушаалаар "Шинжлэх ухаан, технологийн төсөлд шинжээчийг сонгон ажиллуулах, үнэлгээ өгөх журам"-ыг батлуулсан.<br>Хүрсэн түвшин: Шинжлэх ухаан, технологийн төсөлд шинжээчийг сонгон ажиллуулах, үнэлгээ өгөх журмын төсөл<br>Хавсралт: 1 файл | 90% | 90% |
| 3.7.8 | Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын | Үйл ажиллагааны | Боловсруулсан баримт | БСШУ-ны сайдын 2007 оны 276 дугаар | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Төрийн өмчит | Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын захирлын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг | 90% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | захирлын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | зардлаар | бичгийн тоо /Тоо/ | тушаал батлуулсан. | эрдэм шинжилгээний байгууллагын захирлын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. /Баримт бичиг 1/ | шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулсан.<br>Хүрсэн түвшин: Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын захирлын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулсан. | | |
| 3.7.9 | Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/ | ЗГ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолын 38 дугаар хавсралт, 2007 оны 146 дугаар тогтоол батлуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. /Баримт бичиг 1/ | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4 дэх хэсгийг тус тус үндэслэн "Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2406 дугаарын албан бичгээр холбогдох Үндэсний хороод, 15 яамдаас саналыг авч нэгтгэсэн. Монгол Улсын тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан/1/.<br>Хүрсэн түвшин: - Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрэм | 100% | 100% |
| 3.7.10 | Үндэсний шинжлэх ухаан, технологийн | Үйл ажиллагааны | Боловсруулсан баримт | ЗГ-ын 2019 оны 50 дугаар | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 17.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сангийн бүтэц, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | зардлаар | бичгийн тоо /Тоо/ | тогтоол, 2022 оны 497 дугаар тогтоол батлуулсан. | Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. /Баримт бичиг 1/ | Шинжлэх ухаан, технологийн сангийн чиг үүргийн шинжилгээ, судалгааг хийлгэж, үр дүнд тулгуурлан Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, орон тоо, дүрмийн төслийг Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгын хамт боловсруулсан.<br>Хүрсэн түвшин: - Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, дүрмийн төсөл болон БШУ-ны сайдын 2024 оны A/432 дугаар тушаал /бүтэц, орон тоо баталсан/<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.7.11 | Яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийг боловсруулж, батлуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/ | - | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийг боловсруулж, батлуулсан байна. /Баримт бичиг 1/ | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн "Яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрэм"-ийн төслийг боловсруулсан.<br>Хүрсэн түвшин: - Яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрэм"-ийн төсөл | 90% | 90% |
| 3.8. | Шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааны хэрэгжилт, зохицуулалтыг | - | - | - | - | Уг зорилтын хүрээнд төлөвлөсөн 9 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласан. | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ханган ажиллана. | | | | | | |
| 3.8.1 | Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл сонгон шалгаруулж, шалгарсан бүтээлийг урамшуулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Шилдэг бүтээлийн тоо /Тоо/ | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/141 дүгээр тушаал батлуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: "Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл сонгон шалгаруулж, урамшуулах журам"-ын дагуу шилдэг бүтээлийг сонгон шалгаруулж, дагалдах урамшууллыг олгосон байна. /Сайдын тушаал 10 бүтээл/ | Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж, урамшуулах журам"-ын дагуу Шинжлэх ухаан, технологийн салбарын 2024 оны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн шагналд нэр дэвшүүлсэн номын баримт бичгийг 2024.09.12-30-ны өдрүүдэд хүлээн авлаа. Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/43 дугаар тушаалаар байгуулагдсан Шилдэг бүтээл шалгаруулах комисс 2024.12.03-ны өдөр хуралдан, номын төрөлд бүртгүүлсэн 16 бүтээл, Шпрингер Нэйчур олон улсын сэтгүүлийн Дайменшнс мэдээллийн санд бүртгэлтэй олон улсад хэвлэгдсэн өгүүллийг шинжлэх ухааны 6 салбараар хэлэлцэн шалгаруууллаа. Номын төрөлд 4 бүтээл, өгүүлэлд 6 бүтээл тус тус шалгарлаа. Шилдэг бүтээлийн шагналыг 2023.12.10-ны өдрийн "Шинжлэх ухаан-оролцоо 2024" арга хэмжээн дээр гардуулсан. Шилдэг бүтээл бүрийг 10,000,000.0 төгрөгөөр урамшуулах тухай Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалыг батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Хүрсэн түвшин: Номын төрөлд 4 бүтээл, өгүүлэлд 6 бүтээл тус тус шалгарлаа. Шилдэг бүтээлийн шагналыг 2023.12.10-ны өдрийн "Шинжлэх ухаан-оролцоо 2024" арга хэмжээн дээр гардуулсан. Шилдэг бүтээл бүрийг 10,000,000.0 төгрөгөөр урамшуулах тухай Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | засаг, хөгжлийн сайдын тушаалыг батлуулж, хэрэгжилтийг хангал ажилласан. Хавсралт: 1 файл | | |
| 3.8.2 | Шинжлэх ухааны ажилтны өдрийг угтсан “Шинжлэх ухаан, технологи-инновац-2024” сарын арга хэмжээг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Зохион байгуулсан арга хэмжээний тоо /Тоо/ | Жил бүр тогтмол зохион байгуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Сарын аяны төлөвлөгөө боловсруулагдаж, хэрэгжилтийг хангал ажилласан байна. Үзэсгэлэнд оролцсон байгууллага, судалгааны ажил, бүтээлүүд тоо болон чанарын хувьд өмнөх оныхоос дээшилсэн байна. | Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 204 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 2.5 дахь заалтад заасны дагуу 2024 оны шинжлэх ухааны ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/51 тоот тушаалаар баталсан. Шинжлэх ухааны салбарт бүх талын оролцоог бий болгох зорилго бүхий "Шинжлэх ухаан – Оролцоо 2024" цогц арга хэмжээг 2024 оны 12-р сарын 10-ны өдөр Чингис хаан Үндэсний музейд зохион байгуулсан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг 2025 онд багтааж эхлүүлэхээр тусгасан. Эдгээр 14 төслөөс 6 төслийг сонгон тус төслүүдэд шинжлэх ухаан, технологийн салбарын оролцоо, дэмжлэгийг тодорхойлохоор холбогдох төр, хувийн хэвшлийн 350 гаруй төлөөллүүд цугларч гарц, шийдлээ хэлэлцсэн. Мөн үндсэн арга хэмжээнээс гадна зэрэгцээ танхимуудад дээрх 6 төсөлтэй холбоотой сэдвээр хийгдсэн судалгааны ажил, бүтээлийн үзэсгэлэн болон дугуй ширээний ярилцлага, нэтворк танхим зэрэг хэд хэдэн арга хэмжээ зэрэг зохион байгуулсан. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: - Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/51 тоот тушаал<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.8.3 | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт 2024 оноос эхлэн хэрэгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | 2024 онд хэрэгжүүлсэн шинжлэх ухаан, технологийн төслийн тоо /Тоо/ | Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоол батлуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Сонгон шалгаруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, холбогдох шийдвэрийг баталгаажуулж, хэрэгжилтийг хангасан байна. | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн "Мэргэжлийн хорооны бүрэлдэхүүн журам батлах тухай" А/322 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Нийгэм, Инженерчлэл технологи, Хүмүүнлэг, Хөдөө аж ахуй, Анагаах, Байгалийн ухааны Мэргэжлийн хорооны хурлыг 2024 оны 03 дугаар сарын 20-21, 06 дугаар сарын 04-11, 09 дүгээр сарын 04-09, 10 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд тус тус зохион байгуулж, 2024 оноос эхлэн хэрэгжих ОХУ-тай хамтарсан 71 төсөл, БНХАУ болон Тайваньтай хамтарсан 225 төсөл, суурь судалгааны 119 төсөл, улсын захиалгат 10 байгууллагын 51 сэдвийн хүрээнд шалгарсан 11 төсөл, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 13 төсөл, Беларусьтай хамтарсан 4 төсөл, цөм технологи, тэргүүлэх чиглэлийн 2 төсөл, нийт шинжлэх ухаан, технологийн 496 төслийн сонгон шалгаруулалтыг хийж, үр дүнг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/309, Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/42, А/58 дугаар тушаалаар тус тус баталгаажуулж, ШУТС-аас гэрээг байгуулан санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн. 2-рт: Мэргэжлийн хорооны 2024 оны 06 дугаар сарын 04-11, 10 дугаар сарын 03-04-ний | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн хурлаар 2022, 2023 онд хэрэгжиж дууссан шинжлэх ухаан, технологийн төслийн тайлан, үр дүнг хүлээн авах эсэх асуудлыг хэлэлцэж, үр дүнг хорооны хурлын протоколоор албажуулан ШУТСанд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/309, Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/42, мөн А/58 дугаар тушаал<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.8.4 | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж үнэлэлт, дүгнэлт гаргана. | Үйл ажиллагааны зардлаар | Мониторингийн тайлан, дүгнэлт шийдвэрийн тоо /Тоо/ | Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоол батлуулсан. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээ дүгнэлт гарч, санхүүжилтийг шийдвэрлэн, судалгааны үр дүнг чанаржуулах, тасралтгүй үргэлжлэх зохицуулалтыг хангасан байна. | Үндэсний Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран 2024 онд ШУТИС, ХААИС, АШУҮИС, Газарзүй-геоэкологийн хүрээлэн, Одон орон геоэкологийн хүрээлэн зэрэг нийт 24 байгууллагад улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй 172 судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд мониторинг, үнэлэлт дүгнэлт хийсэн.<br>Хүрсэн түвшин: нийт 24 байгууллагад улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй 172 судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд мониторинг, үнэлэлт дүгнэлт<br>Хавсралт: 5 файл | 100% | 100% |
| 3.8.5 | Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, | Үйл ажиллагааны | Санхүүжүүлсэн судалгааны үндсэн | Засгийн газрын 2022 оны 409 дүгээр | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Гэрээний дагуу | Засгийн газрын 2022 оны 409 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн судалгааны үндсэн чиглэлийг | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төвийн судалгааны үндсэн чиглэлд санхүүжилт олгох ажлыг зохион байгуулна. | зардлаар | чиглэлийн тоо /Тоо/ | тогтоол батлуулсан. | санхүүжилт олгогдсон байна. | санхүүжүүлэх журам"-ын дагуу 2024 онд төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдээс ирүүлсэн судалгааны үндсэн чиглэлийн саналд үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн "Судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх зардал батлах тухай"А/206 дугаар тушаалаар ШУА-ийн харьяа 16, төрийн өмчийн 4 их сургуулийн 10 эрдэм шинжилгээний хүрээлэн, БШУЯ-ны харьяа 1 хүрээлэнгийн нийт 27 судалгааны үндсэн чиглэлд 1.1трб.₮-ийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх шийдвэрийг баталгаажуулсан. ШУТС-тай хамтран холбогдох тогтоол, тушаал шийдвэрийн хүрээнд судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх гэрээг байгуулан санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн.<br>Хүрсэн түвшин: - Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн "Судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх зардал батлах тухай"А/206 дугаар тушаалаар ШУА-ийн харьяа 16, төрийн өмчийн 4 их сургуулийн 10 эрдэм шинжилгээний хүрээлэн, БШУЯ-ны харьяа 1 хүрээлэнгийн нийт 27 судалгааны үндсэн чиглэлд 1.1трб.₮-ийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх шийдвэрийг баталгаажуулсан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.8.6 | Шинжлэх ухаан, технологийн Үндэсний хороо | Үйл ажиллагааны | Хорооны төлөвлөгөөнд туссан | 2023 оны үйл ажиллагааны | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: | Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөл(ШУТҮЗ)-ийн 2024 оны төлөвлөгөөг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | болон салбарын харьяа байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана. | зардлаар | арга хэмжээний хэрэгжилтийн явц, хувиар | төлөвлөгөө батлуулсан. | Байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан байна. /100 хувь/ | Боловсрол, шинжлэх ухааны сайд, ШУТҮЗ-ийн дарга Л.Энх-Амгалангаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Төлөвлөгөөнд нийт 2 зорилт, 14 арга хэмжээг тусгаж хэрэгжүүлэхээр баталсан. Мөн БШУ-ны сайдын 2021 оны "Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай" А/366 дугаар тогтоолыг үндэслэн 2024 онд 5 гэрээт шинжээчдийг "Шинжээчээр ажил гүйцэтгүүлэх гэрээ"-гээр авч ажиллуулан ШУТҮЗ-ийн хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллалаа. Мөн УИХ-ын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы хуралдаанаар Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбоотойгоор Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, яамдын саналыг нэгтгэн хууль тогтоомжийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөл(ШУТҮЗ)-ийн 2024 оны төлөвлөгөө /одоогийн ШУТ-ийн Үндэсний хороо/ - 2024 онд 5 гэрээт шинжээчдийг авч ажиллуулсан "Шинжээчээр ажил гүйцэтгүүлэх гэрээ" - Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрмийн төсөл<br>Хавсралт: 5 файл | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.8.7 | Шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Зохион байгуулсан арга хэмжээний тоо /Тоо/ | 5 аймагт зохион байгуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг түгээн дэлгэрүүлэх аяныг 4 аймагт зохион байгуулсан байна. | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Зардлын хуваарилалт батлах тухай" А/101 дүгээр тушаалаар "Шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аян"-д шаардагдах зардлыг тусган батлуулсан. Тус аяныг 2024 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдөр Төв аймагт, 04 дүгээр сарын 09-11-ний өдөр Хэнтий аймагт, 05 дугаар сарын 02-05-ний өдөр Булган аймагт, 05 дугаар сарын 09-10-ны өдөр Сэлэнгэ аймагт тус тус амжилттай зохион байгууллаа. Аяны хүрээнд Шинжлэх ухаан, технологийн талаарх төрийн бодлого төлөвлөлт, шийдвэрийг танилцуулах зорилго бүхий эрдэм шинжилгээний хурал, шинжлэх ухааны судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн үйлчилгээний үзэсгэлэн, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төлөвлөгөөт болон захиалгат сургалт, төр-хувийн хэвшил-эрдэмтдийн хамтын ажиллагааны санамж бичиг зурах арга хэмжээ, мөн шинэ мэдлэг, ноу-хау-г бий болгох гарааны бизнесүүдийн сургалт, "Эрдэм Хакатон" уралдаант тэмцээн зэргийг зохион байгуулсан. Үүнд: төр, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний хүрээлэн төвийн нийт 17 байгууллагын 40 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, үзэсгэлэн гаргаж, аянд 1 аймагт дунджаар 250 гаруй төр, хувийн хэвшлийн байгууллага, судалгааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон дүн мэдээ байна.<br>Хүрсэн түвшин: - 2024 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдөр Төв аймагт, 04 дүгээр сарын | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 09-11-ний өдөр Хэнтий аймагт, 05 дугаар сарын 02-05-ний өдөр Булган аймагт, 05 дугаар сарын 09-10-ны өдөр Сэлэнгэ аймагт тус тус амжилттай зохион байгуулсан тайлан /4 аймаг/<br>Хавсралт: 4 файл | | |
| 3.8.8 | Монгол судлалын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Төлөвлөгөөнд туссан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | Монгол судлалын Үндэсний зөвлөл/орон тооны бус/-ийн тогтоол батлуулсан. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: 2024 оны төлөвлөгөөг МСҮЗ-ийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг хангасан байна. /100 хувь/ | Монгол судлалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар Монгол судлалын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн баталсан. Монгол судлалын үндэсний зөвлөлийн "Төлөвлөгөө батлах тухай" 01 дугаар тогтоолоор 4 чиглэлийн хүрээнд 36 арга хэмжээг зохион байгуулахаар тусгасан. Монгол судлалын үндэсний зөвлөл, Олон улсын Монгол судлалын холбооны үйл ажиллагааг дэмжих, монгол судлалыг сурталчлах, гадаад дахь монгол судлалын төвүүдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн "Зардал батлах тухай" А/129 , "Эрх шилжүүлэх тухай" А/130 дугаар тушаалуудын хэрэгжилтийг хангаж ажилласан. Эрх шилжүүлэх тушаалд холбогдох байгууллагуудад 2024 оны 04 сарын 08-ны өдрийн 4/1361,4/1362,4/1363, 4/1364, 4/1365 албан бичгүүд хүргүүлсэн. Монгол судлалын үндэсний зөвлөлийн "Төлөвлөгөө батлах тухай" 01 дугаар тогтоолоор баталсан 4 чиглэлийн хүрээнд 36 арга хэмжээг зохион байгуулахаар тусгасныг холбогдох гэрээг байгуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: - Монгол судлалын үндэсний зөвлөлийн "Төлөвлөгөө батлах тухай" 01 дугаар тогтоолоор 4 чиглэлийн хүрээнд 36 арга хэмжээ - Монгол судлалын үндэсний зөвлөлийн "Төлөвлөгөө батлах тухай" 01 дугаар тогтоол - Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн "Зардал батлах тухай" А/129 , "Эрх шилжүүлэх тухай" А/130 дугаар тушаал<br>Хавсралт: 5 файл | | |
| 3.8.9 | Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын ажлыг удирдлагаар хангаж ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Барилгын ажлын гүйцэтгэлийн явц, хувиар | 2023 оны эцсийн байдлаар барилгын гүйцэтгэлийн хувь 25 хувьд хүргэсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Цогцолборын барилгын гүйцэтгэл 45 хувьд хүргэсэн байна. | Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын 3 лабораторийн ажил 90%, оффисын барилгын ажил 52%, нийт цогцолборын ажил 57% явагдаж байна. Тус төслийн ирэх жилийн санхүүжилтийг 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар санал хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: - Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын 3 лабораторийн ажил 90%, оффисын барилгын ажил 52%, нийт цогцолборын ажил 57% гүйцэтгэлтэй байна.<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 3.9. | Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны | - | - | - | - | Монгол Улсаас гадаадын улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр байгуулах нийт 30 хэлэлцээрийн төсөлд санал хүргүүлж ажиллав. - Монгол-Германы болон Монгол-Японы ЗГХК-ын хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавина. | | | | | ажиллав. - Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн 2-4 дүгээр шатны хэлэлцээний бэлтгэл ажлыг ханган зохион байгуулав. - Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн хоёр шатны хэлэлцээ, 3 удаагийн уулзалтын бэлтгэл ажлыг ханган зохион байгуулснаар Худалдааны түр хэлэлцээрийн төслийг 2024 онд талууд эцэслэн тохиролцсон болно. - Түнш улс орнууд, олон улсын байгууллагуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр 65 өндөр, дээд түвшний уулзалт, 60 техникийн уулзалтын бэлтгэл ажлыг хангаж, ярианы сэдвийг боловсруулан уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг ханган ажиллав. - 2024 онд АХБ, ЕСБХБ, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлэх нийт 13 төсөл, хөтөлбөрийн Зээлийн хэлэлцээрийг байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан ба холбогдох судалгаанд үндэслэн хөгжлийн түншүүдтэй цаашид хамтран ажиллах стратегийг боловсруулж ажиллав. - "Үндэсний экспортын стратеги" судалгааны ажлын хүрээнд Олон улсын худалдааны төвтэй хамтран ажиллаж, явцын хяналтыг гүйцэтгэн судалгааны багт санал хүргүүлж, судалгааны ажлын эцсийн тайланд дүн шинжилгээ хийж хүлээж авав. - Гадаад худалдааны цахим нэг цонх мэдээллийн систем нэвтрүүлэх ажлыг албан ёсоор эхлүүллээ. Ажлын даалгаврыг батлуулах, тендерийн үнэлгээний хороо байгуулах, тендерийн баримт бичгүүдийг эцэслэн боловсруулах | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилд хяналт тавьж ажиллав. - Монгол, Японы ЭЗТХ-ийн Эдийн засгийн хамтын ажиллагааны дэд хорооны хуралдааны бэлтгэл ажлыг хангаж "Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн ашиглалт, тулгамдсан асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ" сэдвээр хэлэлцүүлэг хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг Японы талтай харилцан тохиролцов. | | |
| 3.9.1 | Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтјан ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Хоёр талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх 5 санамж бичиг, 2 протокол байгуулсан Нийт 22 хэлэлцээрийн төсөл, 26 ярианы сэдэвт санал боловсруулж, холбогдох чиг үүргийн яамдад хүргүүлсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | Монгол Улсын Засгийн газраас гадаадын улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр нийт 30 гэрээ хэлэлцээрийг тохиролцох, байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллав. - Эдийн засаг, хөгжлийн сайдын тэргүүлдэг Монгол-Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн хурлыг 2024.11.18-нд, Монгол, Японы төр, хувийн хэвшлийн XI зөвлөлдөх уулзалтыг 2024.11.28-нд тус тус зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллав. - Монгол Улс, ХБНГУ хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хамтын ажиллагааны 2 баримт бичиг байгуулав. - Их түмэн санаачилга хөтөлбөрийн хүрээнд ОХУ, БНХАУ, БНСУ-тай зам тээвэр, эрчим хүч, худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх 4 жилийн хамтын ажиллагааны үйл ажиллагааны стратеги хөтөлбөрийг байгуулахаар ажиллаж байна. - Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн 2-4 дүгээр шатны хэлэлцээний бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулав. Хэлэлцээр 14 бүлгээс бүрдэх ба хэлэлцээрийн үр дүнд хоёр улс | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хоорондын худалдаан дахь саад тотгор буурч, худалдааг хөнгөвчлөх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах, бүхий л салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, экспортлогчдын зах зээл тэлж, өрсөлдөх чадвар, бараа, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжрах, дотоодод нийлүүлэх барааны үнэ, хангамж тогтворжих ач холбогдолтой. - Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн хоёр шатны хэлэлцээ, 3 удаагийн уулзалтын бэлтгэл ажлыг ханган зохион байгуулснаар Худалдааны түр хэлэлцээрийн төслийг 2024 онд талууд эцэслэн тохиролцсон бөгөөд хэлэлцээр байгуулах асуудлыг Засгийн газрын 2024.11.13-ны өдрөөр хэлэлцэн дэмжсэн болно. Тус хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсаас гарал үүсэлтэй, хөдөө аж ахуйн гаралтай БТКУС-ын 6 орон бүхий 375 төрлийн экспортын бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх нөхцөл бүрдэх юм. | | |
| | | | | | | Хүрсэн түвшин: Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтран ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах чиглэлээр тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. /100 хувь/ | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.9.2 | Худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч салбар хоорондын уялдааг хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Өндөр, дээд түвшний 45 уулзалт, удирдлагын түвшинд 59 уулзалт зохион байгуулсан. Түнш улс орон, олон улсын байгууллагатай хөгжүүлсэн харилцаа, хамтын ажиллагааны мэдээллийн сан, бүрдүүлэн тухай бүр шинэчилж ашигласан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | 1. Түнш улс орнууд, олон улсын байгууллагуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр 65 өндөр, дээд (Сайд болон Дэд сайд) түвшний уулзалт; Төрийн нарийн бичгийн дарга, Сайдын зөвлөх, нэгжийн дарга нарын түвшинд нийт 60 ажлын хэсэг, техникийн уулзалтын бэлтгэл ажлыг хангаж, ярианы сэдвийг боловсруулан уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг хангаж ажиллав. 2. Монгол Улсын Засгийн газар, АХБ 4 жилийн хугацаанд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон үндсэн баримт бичиг болох Түншлэлийн стратегийг шинэчлэн тохиролцох хүрээнд холбогдох судалгааг хийн, шинээр байгуулах 2025-2028 оны Түншлэлийн стратегийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, тохиролцоход дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 3. АХБ-аас Монгол Улсад хуваарилагдах зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тохирох хүрээнд Монгол Улс, АХБ-тай 2024-2027 онд хамтран ажиллах салбар, баримтлах чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тохиролцож Харилцан ойлголцлын санамж бичгийн төслөөр баталгаажуулах бэлтгэл ажлыг хангаж ажилласан. 4. Монгол Улсын Засгийн газар ЕСБХБ-тай шинээр байгуулах Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр, АХБ-тай хамтран хэрэгжүүлэх "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр 2025"-ыг байгуулах, хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эцэслэн тохиролцох ажлыг эхлүүлсэн. 5. АХБ-тай 2024-2027 онд хамтран хэрэгжүүлэх | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боломжит нийт 31 төсөл, арга хэмжээг судалж, Монгол Улсын богино, дунд, урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж буй эсэхийг нягталж, тухай бүр удирдлагад танилцуулж, холбогдох саналыг боловсруулж, салбар яамд болон АХБ-тай хэлэлцсэн. 6. 2024 онд АХБ, ЕСБХБ, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлэх нийт 13 төсөл, хөтөлбөрийн Зээлийн хэлэлцээрийг байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. 7. "Үндэсний экспортын стратеги" судалгааны ажлын хүрээнд Олон улсын худалдааны төвтэй хамтран ажиллаж, явцын хяналтыг гүйцэтгэн судалгааны багт санал хүргүүлж, судалгааны ажлын эцсийн тайланд дүн шинжилгээ хийж хүлээж авав.<br>Хүрсэн түвшин: Худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч салбар хоорондын уялдааг хангах чиглэлд тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. /100 хувь/ | | |
| 3.9.3 | Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлогыг тодорхойлон, импортыг орлох | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулж | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр судалгаа хийж, санал боловсруулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан | Гадаад худалдааны тэнцлийг сайжруулах, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын боломж, гадаад зах зээлийг тэлэх зорилгоор бараа, бүтээгдэхүүнийг татварын нэн таатай нөхцөлөөр экспортлох боломж бүрдүүлэхээр БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хүрээнд 4 шатны албан ёсны яриа хэлэлцээг хийгээд байна. Мөн Монголын хөдөө аж ахуйн гаралтай | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавина. | | | нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж ажилласан. Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолыг батлуулсан. | байна. /100 хувь/ | бүтээгдэхүүнийг татваргүйгээр ОХУ-ын зах зээлд гаргах зорилгоор ЕЭАЗХ-той Худалдааны түр хэлэлцээр байгуулахаар хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсон болно. Тус хэлэлцээрийн үр дүнд Монгол Улсаас гарал үүсэлтэй, харьцангуй давуу талтай хөдөө аж ахуйн гаралтай голлох бараанууд татваргүйгээр экспортлогдох боломжтой бөгөөд махыг квотын хязгаарлалтгүйгээр экспортлох ач холбогдолтой. Худалдааг хөнгөвчлөх бодлогын хүрээнд гадаад худалдааны үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, оролцогч байгууллагууд болон гадаад худалдаа эрхлэгчдэд тулгарч буй хүндрэлүүдийг бууруулах хүрээнд Гадаад худалдааны цахим нэг цонх мэдээллийн систем нэвтрүүлэх ажлыг албан ёсоор эхлүүлээд байна. Тус мэдээллийн системийн "Ажлын даалгавар"-ыг шинэчилсэн бөгөөд АХБ-тай хамтран 3 сарын 21-23-ны өдрүүдэд тус системийн талаарх техникийн сургалт, хэлэлцүүлгийг холбогдох байгууллагуудын төлөөллийг хамруулан зохион байгуулсан. Мөн системийг нэвтрүүлэх, ашиглахтай холбогдуулан хууль эрх зүйн орчны судалгаа, дүн шинжилгээг хийсэн бөгөөд ЦХИХХЯамнаас ГХЦНЦ системийн дүгнэлт, зөвлөмж хүлээн авч, ажлын даалгаврыг баталсан. Тус системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх олон улсын гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар Төрийн худалдан авах ажиллагааны газар тендерийн үнэлгээний хороо байгуулж, тендерийн баримт бичгүүдийг эцэслэн боловсруулсан. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.14. 2 | Орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сангийн бүтэц, платформын судалгааг эхлүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Дата бааз бүрдүүлж, мэдээллийн сангийн судалгаа хийсэн байна.. | Орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сангийн бүтцийг судалж, танилцуулгыг боловсруулан Нэгжийн дарга болон Сайдын зөвлөхөд танилцуулсан. Орон зайн мэдээллийн сангийн программ хангамж болох Газар зүй мэдээллийн систем ArcGIS бүтээгдэхүүнийг судалж, Газарзүйн мэдээллийн систем (GIS) программ хангамж, байршлын мэдээлэл, газрын зураглалын дэлхийн зах зээлд тэргүүлэгч Esri компанитай цахимаар холбогдож, Монгол дахь албан ёсны гэрээт компани болох МонМэп ХХК-тай уулзалт хийж, ArcGIS бүтээгдэхүүний үнийн санал авч удирдлагуудад танилцуулсан. Монгол Улсын орон зайн мэдээллийн дата бааз бүрдүүлж эхэлсэн. Үүнд: Байгалийн үндсэн үзүүлэлт: Нэгдсэн нэг зураглал - Газрын гадарга -Уур амьсгал - Гидрогеологи- Ай сав -Ой сан бүхий газар | 100% | 100% |
| | | | | | | -Ургамал Нийгэм эдийн засгийн үзүүлэлт Нэгдсэн нэг зураглал -Засаг захиргаа -Хот суурингийн чиг үүрэг -Хүн амын байршилт нутагшилт Хүрсэн түвшин: 100 хувь | | |
| 3.14. 3 | Аж үйлдвэрийн төлөвлөлтийн бодлогыг орон зайн судалгаанд | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Дата бааз бүрдүүлж, | Төрийн байгууллагын мэдээллийн сангуудыг цуглуулах ажлын хүрээнд холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудыг судалж, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суурилж бусад төрийн байгууллагын мэдээллийн сангуудыг цуглуулна. | | | | мэдээллийн сангийн судалгаа хийсэн байна. | холбогдох нэгжүүдээс санал авахаар ажиллаж байна. Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн чиглэлээр хийгдсэн өмнөх судалгааны ажлууд болон дата мэдээллийг цуглуулсан. Үүнд: - 17 салбарын хөгжил байршлын судалгаа 2018 он (Үндэсний хөгжлийн газар) - Бүсчилсэн хөгжлийн бодлогын төсөл 2020 он (Макро эдийн засаг ба эрүүл мэнд ТББ) - Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө 2020 (Жайка) - Монгол Улсын үйлдвэржилтийн байршлын схем 2017 (Үндэсний хөгжлийн газар) -Эдийн засгийн нөөцийн дата (shape file)<br>Хүрсэн түвшин: 100 хувь | | |
| 3.15. | Эдийн засгийн салбаруудын үр ашиг, бүтээмжийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа хийж, салбаруудын шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, либералчлалын бодлогыг тодорхойлж, холбогдох байгууллагууд, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдтэй хамтатган үе шаттай хэрэгжүүлэх, | - | - | - | - | Монгол Улсын Засгийн Газрын 100 хоногийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд, ЭЗХЯ-ны удирдлага дор "Монгол Улсын Зэс зэсэн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа" -г хийх ажлын даалгаврыг боловсруулсан. Мөн, худалдан авах ажиллагааг 2024 оны 10 дугаар сард амжилттай зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэн, эхлэлийн тайланг авч, судалгааны ажлыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна. | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавина. | | | | | | | |
| 3.15.1 | Монгол Улсын зэс, зэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгаа хийж, бодит нөхцөл байдалтай уялдуулан судалгааны төслийг боловсруулсан байна. | Монгол Улсын Засгийн Газрын 100 хоногийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд, ЭЗХЯ-ны удирдлага дор "Монгол Улсын Зэс зэсэн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа" -г хийх ажлын даалгаврыг боловсруулсан. Мөн, худалдан авах ажиллагааг 2024 оны 10 дугаар сард амжилттай зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэн, эхлэлийн тайланг авч, судалгааны ажлыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 100 хувь | 100% | 90% |
| 3.15.2 | Монгол Улсын төмөр, ган үйлдвэрлэлийн чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгаа хийж, бодит нөхцөл байдалтай уялдуулан судалгааны төслийг боловсруулсан байна. | Монгол Улсын Засгийн Газрын 100 хоногийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд, ЭЗХЯ-ны удирдлага дор "Монгол Улсын төмөр, ган үйлдвэрийн өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа" -г хийх ажлын даалгаврыг боловсруулсан. Мөн, худалдан авах ажиллагааг 2024 оны 10 дугаар сард амжилттай зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэн, эхлэлийн тайланг авч, судалгааны ажлыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 100 хувь | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.15.3 | Монгол Улсын металл бус эрдэс бодисоор хийсэн барилгын материал үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгаа хийж, бодит нөхцөл байдалтай уялдуулан судалгааны төслийг боловсруулсан байна. | Монгол Улсын Засгийн Газрын 100 хоногийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд, ЭЗХЯ-ны удирдлага дор "Монгол Улсын металл бус эрдэс бодисоор хийсэн барилгын материал үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа" -г хийх ажлын даалгаврыг боловсруулсан. Мөн, худалдан авах ажиллагааг 2024 оны 10 дугаар сард амжилттай зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэн, эхлэлийн тайланг авч, судалгааны ажлыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 100 хувь | 100% | 90% |
| 3.15.4 | Монгол Улсын арьс шир, ноос ноолуур, хувцас үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгаа хийж, бодит нөхцөл байдалтай уялдуулан судалгааны төслийг боловсруулсан байна. | Монгол Улсын Засгийн Газрын 100 хоногийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд, ЭЗХЯ-ны удирдлага дор "Арьс шир, ноос ноолуурын салбарын өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа" -г хийх ажлын даалгаврыг боловсруулсан. Мөн, худалдан авах ажиллагааг 2024 оны 10 дугаар сард амжилттай зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэн, эхлэлийн тайланг авч, судалгааны ажлыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 100 хувь | 100% | 90% |
| 3.15.5 | Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгаа хийж хөтөлбөрийн төслийг | Улсын Их Хурлын даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 83 дугаар захирамжаар Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт боловсруулах Х.Ганхуяг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгт сүүлийн 2 жилийн | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бууруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ. | | | | боловсруулсан байна. | хугацаанд хийсэн зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн талаарх ажлын дэлгэрэнгүй тайланг ажлын хэсгийн гишүүд болон бусад зөвшөөрөл олгодог төрийн захиргааны байгууллагын төлөөллүүдэд танилцуулав. ТНБД-ын тушаалаар Нийслэл, дүүргийн албан хаагчдыг оролцуулсан ажлын хэсэг байгуулж дүүргээс олгодог зөвшөөрлийн бодлогын даалгавар боловсруулах уулзалтыг холбогдох төрийн байгууллагуудад очиж тухай бүрд нь холбогдох албан хаагчидтай зөвшөөрлийн процессын талаарх мэдээллийг солилцон ажиллаж байна. Мөн 2024 оны III, IV улиралд Зөвшөөрлийн цахим системд шинээр БЯ-аас олгож байгаа дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах энгийн зөвшөөрлийг цахимжуулах ажлын хүрээнд мэргэжилтнээс зөвшөөрөл бүртгэх цонхны өөрчлөлт мөн нийт 415 мэргэжлийн чиглэл, индексийн хөтөлбөрийн боловсролын түвшин тус бүрээр бодит орчинд нэвтрүүлэхээр ажиллаж байна. АҮЭБЯ-аас олгож байгаа цацрагийн үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийн шинжилгээний ажил хийгдэж дууссан бөгөөд хөгжүүлэлтийн шатанд явагдаж байна. Зөвшөөрлийн тухай хуульд таслалаар оруулсан зөвшөөрлүүдийг тусдаа зөвшөөрөл гэж бүртгэхээр шийдвэрлэсний дагуу туршилтын орчинд цацрагийн үйл ажиллагаатай холбоотой 4 зөвшөөрлийг 15 зөвшөөрөл болгон салгаж туршилтын орчинд тохируулах ажил хийгдээд байна. И-бизнес платформоос дундын систем ашиглан зөвшөөрлийн цахим систем | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хооронд зөвшөөрлийн хүсэлт гаргах, илгээх сервисийн хөгжүүлэлт хийгдэж систем хооронд тестийн орчинд мэдээлэл дамжуулах боломжтой болсон. Нэмэлтээр зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд, зөвшөөрлийн мэдээлэл лавлах сервис хөгжүүлэлт, И-бизнес-ээс ирсэн хүсэлтийн бүрдүүлэх материалыг url-р харуулах хөгжүүлэлт хийгдээд байна.<br>Хүрсэн түвшин: 100 хувь<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.16. | Хувийн хэвшлийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад төрийн оролцоог багасгах үндсэн чиглэлийн бодлого боловсруулах, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход чиглэсэн арга хэмжээг тодорхойлох, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг уялдуулан | - | - | - | - | Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 албан даалгаварт тусгагдсан Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Бизнес эрхлэх орчны судалгаа"-г хийж гүйцэтгэхийг даалгасан. Энэхүү ажлын хүрээнд Ерөнхий сайдын дэргэдэх "Эдийн Засгийн бодлогын зөвлөл"-ийн ажлын албатай уулзалт хийж. Зөвлөлөөс гарсан шийдвэр, үйл ажиллагааны чиглэлийн талаарх мэдээллийг авч, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцов. Мөн "Эдийн засаг, хөгжлийн яамны удирдлага дор худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих экосистемийн хүрээнд төрийн болон хэрэгжүүлэгч агентлагуудын үүрэг хариуцлагын давхардлын судалгаа"-г хийх ажлын даалгаврыг боловсруулан. 10 дугаар сард худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, судалгаа хийх байгууллыг сонгон шалгаруулав. Судалгааны ажлын эхлэлийн тайланг хүлээн авч, судалгааны ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх удирдамжийг өгч ажиллав. Үүнээс гадна | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулна. | | | | | "Аялал жуулчлалын салбарын хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээ хийж, хөдөлмөр эрхлэлтийн урьдчилсан тооцоолол, судалгаа хийх" ажлын даалгаврыг гарган, худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан судалгааны ажлыг эхлүүлэх бэлтгэлийг ханган ажиллаж байна.Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 албан даалгаварт тусгагдсан Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Бизнес эрхлэх орчны судалгаа"-г хийж гүйцэтгэхийг даалгасан. Мөн "Хувийн хэвшил, Бизнес эрхлэгчдийн тулгамдаж буй асуудал тодорхойлох, шаардлагатай хууль, эрх зүйн орчныг сайжруулах талаар судалгаа" хийх ажлын даалгаврыг боловсруулсан. Судалгааны ажлын эхлэлийн тайланг хүлээн авч, судалгааны ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх удирдамжийг өгч ажиллав. | | |
| 3.16.1 | Хувийн хэвшил, бизнес эрхлэгчдийн тулгамдаж буй асуудал тодорхойлох, шаардлагатай хууль зүйн орчныг сайжруулах талаар судалгаа боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Судалгааны төслийн эхний хувилбарыг боловсруулсан байна. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 албан даалгаварт тусгагдсан Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Бизнес эрхлэх орчны судалгаа"-г хийж гүйцэтгэхийг даалгасан. Энэхүү ажлын хүрээнд Ерөнхий сайдын дэргэдэх "Эдийн Засгийн бодлогын зөвлөл"-ийн ажлын албатай уулзалт хийж. Зөвлөлөөс гарсан шийдвэр, үйл ажиллагааны чиглэлийн талаарх мэдээллийг авч, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцов. Мөн "Эдийн засаг, хөгжлийн яамны удирдлага дор худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих экосистемийн хүрээнд төрийн болон хэрэгжүүлэгч агентлагуудын үүрэг | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хариуцлагын давхардлын судалгаа"-г хийх ажлын даалгаврыг боловсруулан. 10 дугаар сард худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, судалгаа хийх байгууллыг сонгон шалгаруулав. Судалгааны ажлын эхлэлийн тайланг хүлээн авч, судалгааны ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх удирдамжийг өгч ажиллав. Үүнээс гадна "Аялал жуулчлалын салбарын хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээ хийж, хөдөлмөр эрхлэлтийн урьдчилсан тооцоолол, судалгаа хийх" ажлын даалгаврыг гарган, худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан судалгааны ажлыг эхлүүлэх бэлтгэлийг ханган ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 100 хувь | | |
| 3.16.2 | Жижиг, дунд болон гарааны бизнесийг дэмжих бодлого, тогтолцоог хөгжүүлж, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаална. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, /хувиар/ | - | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Судалгааны төслийг боловсруулсан байна. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 албан даалгаварт тусгагдсан Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Бизнес эрхлэх орчны судалгаа"-г хийж гүйцэтгэхийг даалгасан. Мөн "Хувийн хэвшил, Бизнес эрхлэгчдийн тулгамдаж буй асуудал тодорхойлох, шаардлагатай хууль, эрх зүйн орчныг сайжруулах талаар судалгаа" хийх ажлын даалгаврыг боловсруулсан. Судалгааны ажлын эхлэлийн тайланг хүлээн авч, судалгааны ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх удирдамжийг өгч ажиллав.<br>Хүрсэн түвшин: 100 хувь | 100% | 90% |
| 3.17. | Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн | - | - | - | - | Мега төслүүдийг хариуцсан салбар яамдад болох Эрчим хүчний яам, ЦХИХХЯ, БОУАӨЯ-ны газрын дарга нар, | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, оролцоог нэмэгдүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, эдийн засгийн коридорын төслүүдийг идэвхжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | холбогдох хүмүүстэй уулзалтыг зохион байгуулж төслүүдийн төлөвлөлт, мониторинг, үнэлгээ болон төслүүдийг хэрэгжүүлэхэд учирч буй саад бэрхшээлүүдийн талаар мэдээлэл солилцов. Зам, тээврийн салбарын төслүүдийн талаар ЗТЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Сайдын зөвлөх, ГХЯ-ны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын асуудал хариуцсан ажилтан нартай 2024.09.17-нд уулзаж санал солилцсон бөгөөд Зам, тээврийн сайдын зөвлөх 2024.09.18-ны өдөр тус газрынханд зориулж Төмөр замын төслүүдийн талаар танилцуулга хийсэн. Мөн мега төслүүдийг хариуцсан яамд, төслүүдийн нэгжийн удирдлага, ажилтнуудтай 2024.09.23-ны өдөр хийсэн уулзалтад ЗТЯ-ны төлөөллийг оролцуулсан. Дээрх уулзалтуудын үр дүнд Мега төслүүдийн хэрэгжилтийн үнэлгээг Ерөнхий сайдад харуулах цахим платформд төслүүдийн төлөвлөлтийг оруулж, мониторинг, үнэлгээг тогтмол оруулж байна. Салбар яамдад мега төслүүдийн ТЭЗҮ боловсруулах болон гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын явцын талаар мэдээлэл авахаар 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 01/2174 тоот албан бичгийг хүргүүлсэн. Салбар яамд болон төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн мега төслүүдийн техник эдийн засгийн үндэслэл шинээр хийх болон шинэчилж хийх төслүүдийн жагсаалт гаргасан. | | |
| 3.17.1 | Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг | Үйл ажиллагааны | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: | Мега төслүүдийг хариуцсан салбар яамд болох Эрчим хүчний яам, ЦХИХХЯ, БОУАӨЯ-ны газрын дарга нар, холбогдох | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулна. | зардлаар | | | Тухай бүр холбогдох арга хэмжээг авч, зохион байгуулсан байна. /100 хувь/ | хүмүүстэй уулзалтыг зохион байгуулж төслүүдийн төлөвлөлт, мониторинг, үнэлгээ болон төслүүдийг хэрэгжүүлэхэд учирч буй саад бэрхшээлүүдийн талаар мэдээлэл солилцов. Зам, тээврийн салбарын төслүүдийн талаар ЗТЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Сайдын зөвлөх, ГХЯ-ны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын асуудал хариуцсан ажилтан нартай 2024.09.17-нд уулзаж санал солилцсон бөгөөд Зам, тээврийн сайдын зөвлөх 2024.09.18-ны өдөр тус газрынханд зориулж Төмөр замын төслүүдийн талаар танилцуулга хийсэн. Мөн мега төслүүдийг хариуцсан яамд, төслүүдийн нэгжийн удирдлага, ажилтнуудтай 2024.09.23-ны өдөр хийсэн уулзалтад ЗТЯ-ны төлөөллийг оролцуулсан. Дээрх уулзалтуудын үр дүнд Мега төслүүдийн хэрэгжилтийн үнэлгээг Ерөнхий сайдад харуулах цахим платформд төслүүдийн төлөвлөлтийг оруулж, мониторинг, үнэлгээг тогтмол оруулж байна.<br>Хүрсэн түвшин: 100 хувь<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.17.2 | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төслүүдэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл, хөтөлбөрүүдийн бэлэн байдал, хэрэгжилтийг | Салбар яамдад мега төслүүдийн ТЭЗҮ боловсруулах болон гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын явцын талаар мэдээлэл авахаар 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 01/2174 тоот албан бичгийг хүргүүлсэн. Салбар яамд болон төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн мега төслүүдийн техник эдийн засгийн үндэслэл шинээр хийх болон шинэчилж хийх төслүүдийн жагсаалт гаргасан. | 90% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангуулах ажлыг зохион байгуулах, салбар яамд, холбогдох төрийн байгууллагад зөвлөмж, чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. /100 хувь/ | Төслийн нэгдсэн удирдлагаар хангах талаар оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, төслийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ТЭЗҮ тодотгол хийх шаардлагатай төслүүдийн төлөвлөлтийг салбар хоорондын уялдаа хангах чиглэлээр Эрдэнэс ҮТП ХХК-тай хамтран Хөгжлийн төлөвлөгөөнд санал хүргүүлсэн. Мөн төсөл, хөтөлбөрийн бэлэн байдал, санхүүжилтийн хувилбарыг шийдвэрлэх хүрээнд Европийн сэргээн босголт ба Хөгжлийн банк, Азийн Хөгжлийн банк, Дэлхийн банкны төлөөллүүдтэй уулзалт хийж, түншлэлийн стратеги болон холбогдох баримт бичгүүдэд тусгуулах талаар санал хүргүүлсэн. Монгол-Франц хамтарсан ураны төслийн "хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төслийн хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн гэрээний хувилбарыг Засгийн Газрын хуралдаанаар танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Эдийн засаг, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажлын дэд хэсгийн харилцан ойлголцсон болон ойлголцож эцэслээгүй зарчмын ач холбогдолтой саналуудыг хавсралтын хамт зөвлөмж байдлаар хүргүүлсэн. | | |
| | | | | | | Хүрсэн түвшин: Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл, хөтөлбөрүүдийн бэлэн байдал, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 01/2174 болон 12 дугаар сарын 02-ны 01/2571 тоот албан бичгүүдийг хүргүүлж, стратегийн түншлэлийн баримт бичигт төслүүдийг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусган, ажлын хэсгийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан. | | |
| 3.18. | Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангана. | - | - | - | - | “Эрдэнэс ҮТП” ХХК-ны удирдлагуудтай 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр уулзалт зохион байгуулж Катодын зэс боловсруулах үйлдвэрийн цогцолбор, Ган боловсруулах төслийн цогцолбор, Кокс-химийн үйлдвэрийн цогцолбор, Нүүрс-химийн үйлдвэрийн цогцолбор зэрэг төслүүдийн төлөвлөлтийг хэрхэн гаргах, хэрэгжилтэд хэрхэн мониторинг хийх тал дээр зөвлөлдөн, тус уулзалтаас хойш “Эрдэнэс ҮТП” ХХК-аас үнэлгээнд шаардлагатай мэдээллийг тогтмол авч, дээрх төслүүдийн хэрэгжилтэд мониторинг, үнэлгээ хийж байна. “Газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр уулзалт зохион байгуулж, төслийн төлөвлөгөө, мониторинг, үнэлгээний талаар харилцан санал солилцов. Төслийн хэрэгжилтийг хүний оролцоогүйгээр хянах самбар бүхий мониторинг, дашбоард хөгжүүлэлт хийх чиглэлээр зөвлөх үйлчилгээ авах, Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй 3 удаагийн уулзалт зохион байгуулж төслийн үе шатыг 4, үе шат бүрийг 5 үндсэн үйл явцтайгаар нийт 20 жишиг шалгуур үзүүлэлт боловсруулж хүргүүлсэн. Үндсэн цэсэд тавигдах хэрэгцээ, шаардлагыг мэдээлэл оруулах хэрэглэгч тус бүрээр тодорхойлж, харагдах нүүр хэсгийн эхний хувилбарыг гаргаж санал авахаар танилцуулсан. Одоогийн байдлаар Засгийн газрын бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мониторинг хийх, хэрэгжилтийг үнэлэх аргачлал байдаг бол харин томоохон мега төслүүдийн хэрэгжилтэд мониторинг хийх, үнэлэх аргачлал, журам, стандартууд хараахан байхгүй байна. Иймд энэхүү аргачлал, журмын төслийг боловсруулах үүрэг бүхий дотоодын зөвлөхийг авч ажиллуулах бэлтгэл ажлыг НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлж, улмаар дотоодын зөвлөх тухайн аргачлал, стандартыг боловсруулах ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлүүлээд байна. Бэрхшээлүүдийг шийдвэрлэх зорилгоор эхний ээлжид Мега төслүүдийг хэрэгжүүлэх хууль эрхзүйн орчны бүрэн шинжилгээг хийх, хуулийн төслүүдийг боловсруулах дотоод зөвлөх авах ажлыг НҮБХХ-т хандан, зөвлөхийн ажлын даалгавар болон холбогдох бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | | |
| 3.18.1 | Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. /100 хувь/ | Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мониторингийн дашбоард хөгжүүлэлт хийх чиглэлээр Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй 3 удаагийн уулзалт зохион байгуулж төслийн үе шатыг 4, үе шат бүрийг 5 үндсэн үйл явцтайгаар нийт 20 жишиг шалгуур үзүүлэлт боловсруулж хүргүүлсэн. Үндсэн цэсэд тавигдах хэрэгцээ, шаардлагыг мэдээлэл оруулах хэрэглэгч тус бүрээр тодорхойлж, харагдах нүүр хэсгийн эхний хувилбарыг гаргаж санал авахаар танилцуулсан. Төслийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийж, төсөл тус бүрээр эрсдэлийн шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлсэн. "Эрдэнэс ҮТП" ХХК-ны удирдлагуудтай 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр | 100% | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уулзалт зохион байгуулж Катодын зэс боловсруулах үйлдвэрийн цогцолбор, Ган боловсруулах төслийн цогцолбор, Кокс-химийн үйлдвэрийн цогцолбор, Нүүрс-химийн үйлдвэрийн цогцолбор зэрэг төслүүдийн төлөвлөлтийг хэрхэн гаргах, хэрэгжилтэд хэрхэн мониторинг хийх тал дээр зөвлөлдөн, тус уулзалтаас хойш “Эрдэнэс ҮТП” ХХК-аас үнэлгээнд шаардлагатай мэдээллийг тогтмол авч, төслүүдийн хэрэгжилтэд мониторинг, үнэлгээ хийж байна. “Газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр уулзалт зохион байгуулж, төслийн төлөвлөгөө, мониторинг, үнэлгээний талаар харилцан санал солилцож, зөвлөмж, чиглэл хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 100 хувь<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.18.2 | Хөгжлийн төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Хөгжлийн төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, зөвлөмж өгсөн байна. /100 хувь/ | Засгийн газрын бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд мониторинг хийх, хэрэгжилтийг үнэлэх аргачлал нь томоохон мега төслүүдийн хэрэгжилтэд мониторинг хийх, үнэлэх аргачлал, журам, стандартууд хараахан нийцэхгүй байдалтай байна. Бэрхшээлүүдийг шийдвэрлэх зорилгоор эхний ээлжид Мега төслүүдийг хэрэгжүүлэх хууль эрхзүйн орчны бүрэн шинжилгээг хийх, хуулийн төслүүдийг боловсруулах дотоод зөвлөх авах ажлыг НҮБХХ-т хандан, зөвлөхийн ажлын даалгавар болон холбогдох бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Төслүүдийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийг хянах зарчмыг | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тодорхойлж, төсөл тус бүрээр хэрэгжилтийн түвшний үнэлгээг гаргаж, УИХ болон ЗГ-т танилцуулах тогтоолын төсөл, хуулийн төслүүд боловсруулах бэлтгэл ажлыг хийсэн. Мега төслүүдийг хэрэгжүүлэхэд учрах саад бэрхшээлүүдийг хэлэлцэх, холбогдох тогтоол, шийдвэрүүдийн төслийг хэлэлцүүлэх, мөн салбар хоорондын уялдааг хангах үүрэг бүхий Үндэсний хороо байгуулах Засгийн газрын тогтоолын төсөл, Үндэсний хорооны бүрэлдэхүүн, танилцуулгыг боловсруулан Засгийн газрын гишүүд, яамдад санал авахаар хүргүүлсэн. Монголын хүнд үйлдвэрийн эрдэс холбоо ГҮТББ-тай уулзалт зохион байгуулж, мега төслүүдийн хэрэгжүүлэх шатанд учирч буй АМНАТ-ын давхцал, хүний нөөцийн асуудлаар урьдчилсан үнэлгээ хийж, танилцуулсан. Мега төслүүдийг хэрэгжүүлэхэд учрах саад бэрхшээлүүдийг хэлэлцэх, холбогдох тогтоол, шийдвэрүүдийн төслийг хэлэлцүүлэх, мөн салбар хоорондын уялдааг хангах үүрэг бүхий Үндэсний хороо байгуулах Засгийн газрын тогтоолын төсөл, Үндэсний хорооны бүрэлдэхүүн, танилцуулгыг боловсруулан Засгийн газрын гишүүд, яамдад санал авахаар хүргүүлсэн. "Эгийн голын усан цахилгаан станц" төслийн зөвшилцөх буюу замын зураглал боловсруулах уулзалтаар төсөлтэй холбоотой техник, эдийн засгийн үндэслэл, цахилгаан дамжуулах агаарын шугам, байгаль орчин, экосистемийн асуудалтай холбоотой зөвлөмж хүргүүлсэн. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: 100 хувь<br>Хавсралт: 5 файл | | |
| 3.19. | Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцох, хэрэгжилтэд хяналт тавина. | - | - | - | - | "Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийн төсөл, арга хэмжээнүүдийн жагсаалтыг шинэчлэх талаар хөрш орнуудын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж тохирсон бөгөөд үүнийгээ тогтсон журмын дагуу харилцан захидал, нот бичиг солилцон баталгаажуулсан бөгөөд энэ талаар холбогдох яам, газруудад мэдээлсэн. Мөн Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах Үндэсний ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 123 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан ба тус ажлын хэсгийг хуралдуулах тухай 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03/2594 тоот албан бичгийг холбогдох яамд, байгууллагуудад хүргүүлсэн. . | 100% | 90% |
| 3.19.1 | Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцоно. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцож эцэслэсэн байна. /100 хувь/ | Москва хотноо 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр болсон ЭЗК-ын хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлаарх гурван талын Ажлын хэсгийн 6 дугаар хуралдаанаар "Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийн төсөл, арга хэмжээнүүдийн жагсаалтыг шинэчлэх санаачилга гарч, талууд 2023 оны 9 дүгээр сараас эхлэн мөн ондоо 2 удаа, 2024 он гараад 1,4, 5, 6, 8 саруудад харилцан санал солилцсоны үр дүнд 2024 оны 9 дүгээр сар гэхэд 33 төсөл, арга хэмжээ бүхий жагсаалтыг эцэслэн тохирсон бөгөөд энэ тухай талууд | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харилцан захидал солилцохоор заасны дагуу хятадын тал 2024 оны 10 дугаар сарын 13-ны өдөр, оросын тал 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн тус тус захидал ирүүлсэнд монголын талаас Монгол Улсын Засгийн газрын Тэргүүн Шадар бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/2332 тоот албан бичгийг ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн сайд М.Г.Решетниковт, мөн өдрийн 01/2336 тоот албан бичгийг БНХАУ-ын ХШХ-ны дарга Жөн Шаньжэд тус тус хүргүүлэхээр ГХЯ-нд 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 03/2362 тоотоор явуулсан. Ингэснээр төсөл, арга хэмжээний жагсаалтыг эцэслэн тохирох ажиллагаа хийгдэж дууссан болно.<br>Хүрсэн түвшин: 100 хувь<br>Хавсралт: 4 файл | | |
| 3.19. 2 | Төсөл хөтөлбөрүүдийг тохиролцож, хэрэгжилтэд хяналт тавина. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Төсөл хөтөлбөрүүдийг тохиролцож хэрэгжилтэд хяналт тавьсан байна. /100 хувь/ | 1. "Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх монголын талын Үндэсний ажлын хэсгийг шинэчлэн байгуулах Ерөнхий сайдын захирамж гаргуулахаар төслийг 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 01/2175 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд Ерөнхий сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 123 тоот захирамж гарч, Үндэсний ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Уг захирамжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, ажлын хэсгийн хуралдааныг хийх санал бүхий албан бичгийг холбогдох яам, байгууллагуудад хүргүүлсэн. 2. Ерөнхий сайдын 2024 оны | 70% | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 01 тоот албан даалгаварт "Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-т туссан төсөл, арга хэмжээг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан эрчимжүүлэхийг чиглэл болгосны дагуу энэ асуудлаар 12 дугаар сард багтаан уулзалт зохион байгуулах тухай 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01/2220 тоот албан бичгийг зарим яамдын сайд нарт болон холбогдох бусад байгууллагуудад хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 70 хувь<br>Хавсралт: 4 файл | | |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | |
| 4.1. | Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгож, санхүү, хөрөнгө оруулалт, хууль, эрх зүй болон гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах асуудлыг хариуцах, яамны өдөр тутмын хэвийн | - | - | - | - | Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу албан хаагчдыг 2024 оны эхний хагас жилийн байдлаар ажлын гүйцэтгэлийг үнэлж, мөнгөн урамшууллыг олгосон. Яамны албан хаагчдын эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөнийг хангах хүрээнд "Цэвэр байгаль- цэнгэг агаар" явган аяллыг 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Тэрэлж-Горхийн цогцолбор Мэлхий хад-Арьяабал маршрутын дагуу зохион байгуулж, нийт 80 гаруй албан хаагчид идэвхтэй оролцсон. Яамны албан хаагчдын дунд спортын 5 төрлөөр газар хоорондын "Шилжин явах цом"-ыг 2024 оны 4 дүгээр сарын 25-27-ны өдөр зохион байгуулж, нийт 80 гаруй албан хаагчид идэвхтэй оролцсон. Албан хаагчдын | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг хангана. | | | | | ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд "Орон сууцны дэмжлэг үзүүлэх журам"-ын төсөлд санал авахаар холбогдох газруудад дотоод албан тоот хүргүүлсэн.Тэргүүн Шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025 оны төсөв 2026-2027 оны төсвийн төсөөллийг салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг үйл ажиллагааныхаа цар хүрээг нарийвчлан үндэслэлтэй бодитой төлөвлөж, төсөв, санхүүгийн мэдээллээр удирдлагыг хангаж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг тухай бүрд нь санхүүжүүлж, гүйцэтгэлийг хянан, үр дүнг тайлагнан ажиллаж байна.Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах, хянах болон төрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, удирдлагын шийдвэр үйл ажиллагааг хуульд нийцүүлэх, тэдгээрийн эрх зүйн үндэслэлийг хянах чиг үүргийг хэрэгжүүлсэн.Сайдын ажлын чиг үүргийн хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамны Фейсбүүк хуудас болон веб сайтын хэвийн үйл ажиллагааг хангаж байна. | | |
| 4.1.1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, | Үйл ажиллагааны | Хэрэгжилтийн явц, хувиар | ТЖАХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: ТЖАХ-ийн 2024 | Эдийн засаг, хөгжлийн яамны байгууллагын болон нийт албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг удирдлагын мэдээллийн цахим сан буюу | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тайланг хагас, бүтэн жилээр гаргаж дүгнүүлнэ. | зардлаар | | тайланг дүгнүүлсэн. | оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тайланг гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн байна. /100 хувь/ | www.plan.igovernment.mn программд зохион байгуулалтын нэгж, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус бүрээр баталгаажуулан гаргаж, нэгжийн даргаар үнэлүүлэн, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар "Үнэлгээний баг"-ийг байгуулан төрийн жинхэнэ албан хаагчийн дундаж үнэлгээ 95.3 хувьтай үнэлэгдэж, үр дүнгийн урамшууллыг зохих журмын дагуу олгуулсан. Эдийн засаг, хөгжлийн яамны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1-8 дугаар сарын биелэлт, хагас жилийн биелэлтийг тус тус гаргуулан, ХШҮДАГ хүргүүлсэн. ЭЗХЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар ТЖАХ болон нэгжийн, байгууллагын тайланг нэгтгэж байна. Үнэлгээний багийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн А/285 дугаартай тушаалаар байгуулсан. Үнэлгээний багийг 2024 оны 12 дугаар сарын 19-нд хуралдуулж, эцсийн дүнг удирдлагад танилцуулж, зохих журмын дагуу дүгнүүлнэ.<br>Хүрсэн түвшин: Үнэлгээний багийг 2024 оны 12 дугаар сарын 19-нд хуралдуулж, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн дүнг удирдлагад танилцуулна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 4.1.2 | Яамны үйл ажиллагаатай холбогдох төлөвлөгөөг | Үйл ажиллагааны зардлаар | Төлөвлөгөөний тоо /тоо/ | Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Засгийн газрын үйл | Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн А/09 дүгээр тушаал, 2024 оны 11 дүгээр сарын 1-ны А/269 тушаалаар "Эдийн засаг, хөгжлийн яамны | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулах, батлуулна. | | | , батлуулсан. | ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. /1 төлөвлөгөө/ | гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай" 2 удаа батлуулсан. Нийт эхний хагас жилд 98 албан хаагч, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан/ программ болон цахим/. Нийт 24 зорилт, 142 арга хэмжээ батлагдсан. Мэдээллийн удирдлагын цахим сан буюу plan.igovernment.mn программд 106 албан хаагч, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулсан. Мөн 2024 оны сургалтын төлөвлөгөө, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус батлуулсан.<br>Хүрсэн түвшин: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 1-ны өдрийн А/269 тушаалаар "Эдийн засаг, хөгжлийн яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай" батлуулсан.<br>Хавсралт: 4 файл | | |
| 4.1.3 | Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэвийн явуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэвийн үйл ажиллагааг хангасан байх, хувиар | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэвийн ажилласан. | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн өдөх тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна. /100 хувь/ | Эдийн засаг, хөгжлийн яаманд 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар Нийт 3988 албан бичиг ирснийг албан бичиг хөтлөлтийн оффис 365 программд тухай бүр бүртгэж, албан бичгийн шийдвэрлэлт хянаж тавьж, сар бүр албан бичгийн тайланг гарган удирдлагад танилцуулсан. Албан бичгийн шийдвэрлэлтийн 92%-тай байна. Төрийн байгууллага хоорондын цахим албан бичиг солилцох ажлын хүрээнд нийт 467 албан бичгийг цахимаар хүлээн авч ажилласан.Байгууллагаас албажиж гарсан албан бичгийн явах хувийг дугтуйлан хаяглаж "Монгол шуудан" шуудангийн үйлчилгээгээр | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дамжуулан 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нийт 3123 албан бичгийг бүртгэл хөтлөн иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүргүүлсэн. 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар хэвлэмэл хуудасны зарцуулалт: Сайдын тушаал 240230, ТНБД-ын тушаал 241074, Сайдын А4 бланк 241001, Сайдын А5 бланк 240827 ширхэг байна.Төрийн байгууллага хоорондын цахим албан бичиг солилцох ажлын хүрээнд ERP цахим системеер дамжуулан Нийт 200 албан бичгийг цахимаар хүргүүлж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Байгууллага хоорондын цахим албан бичиг солилцох ажлын хүрээнд ERP цахим системээр дамжуулан Нийт 200 албан бичгийг цахимаар хүргүүлж ажилласан. | | |
| 4.1.4 | МУ-ын ерөнхийлөгчийн зарлиг, УАБЗ-ийн зөвлөмж, УИХ-ын болон ЗГ-ын тогтоол, ЕС-ын захирамж, албан даалгавар, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл хууль, тогтоомжийн биелэлтийг сар бүр болон хагас, бүтэн жилээр | Үйл ажиллагааны зардлаар | Биелэлтийн явц, хувиар | 2023 оны биелэлтийг сар бүр болон хагас, бүтэн жилээр газруудаас авч нэгтгэн, холбогдох газарт хүргүүлсэн. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Биелэлтийг газруудаас нэгтгэн авч холбогдох газарт хүргүүлнэ. /100 хувь/ | Эдийн засаг, хөгжлийн яамны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг сар бүрийн 05-ны дотор, хагас болон бүтэн жилийн тайланг яамны дотоод бүтцийн нэгжүүдээс med.igovernment.mn программаар гаргуулан, нэгтгэн хуулийн хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлсэн.Эдийн засаг, хөгжлийн яамны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын хууль 10 шийдвэрийн 22 заалт 100 хувь, Улсын Их Хурлын тогтоол 25 шийдвэрийн 64 заалт 99.0 хувь, УИХ-ын Байнгын хорооны тогтоол 11 шийдвэрийн 34 заалт 100 хувь, Ерөнхийлөгчийн зарлиг 3 шийдвэрийн 6 заалт 90 хувь, Засгийн газрын тогтоол 37 шийдвэрийн 62 заалт 99.4 хувь, Засгийн | 100% | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | газруудаас нэгтгэн авч, холбогдох газарт хүргүүлнэ. | | | | | газрын хуралдааны тэмдэглэл 65 шийдвэрийн 143 заалт 99.5 хувь, Засгийн газрын албан даалгавар 3 шийдвэрийн 8 заалт 100 хувь, Ерөнхий сайдын захирамж 8 шийдвэрийн 9 заалт 96.2 хувь, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 1 шийдвэрийн 2 заалт 100 хувийн хэрэгжилттэй. Нийт 322 заалт бүрэн хэрэгжсэн 100 хувийн хэрэгжилттэй, хэрэгжих шатандаа байгаа буюу 70 хувийн хэрэгжилттэй 8 заалт, хугацаа болоогүй 19, нийт үнэлэгдсэн 349 заалтын хэрэгжилт дунджаар 99.2 хувьтай тайлагнаж, ХШҮДАГ-т хүргүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын 2024 оны 10 дугаар сарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 201 заалтын биелэлт 94.2 хувьтай нэгтгэн гаргаж, ХШҮДАГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-ын ХХГ-т уламжилж чиг үүрэг шилжсэн 64 заалтыг хасуулсан.2024 оны 11 дүгээр сарын хэрэгжилтийн 137 заалтын биелэлт 95.58 хувьтай гарсан.<br>Хүрсэн түвшин: 2024 оны 10 дугаар сарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 201 заалтын биелэлт 94.2 хувьтай нэгтгэн гаргаж, ХШҮДАГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-ын ХХГ-т уламжилж чиг үүрэг шилжсэн 64 заалтыг хасуулсан.2024 оны 11 дүгээр сарын хэрэгжилтийн 137 заалтын биелэлт 95.58 хувьтай гарсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 4.1.5 | Яамны үйл ажиллагаатай хамааралтай | Үйл ажиллагааны | Нэгтгэсэн тайлангийн тоо /тоо/ | 2023 онд үйл ажиллагаатай холбогдох | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: | Байгууллагын 2024 оны эхний хагас жилийн тайлан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 97.9 хувийн | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тайланг гаргана. | зардлаар | | тайланг тухай бүр гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн. | Хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох тайланг гаргасан байна. /3 тайлан/ | биелэлттэй, Төрийн албаны хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт, Байгууллагын ил тод байдлын хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар гарган хэрэгжилтийг тайлагнаж, ХШҮГ-т дотоод бичгээр хүргүүлсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг яамны дотоод бүтцийн нэгжүүдээс med.igovernment.mn программаар гаргуулан нэгтгэн сар бүрийн 05-ны ХШҮДАГ-т хүргүүлсэн. Хавсралт файл хавсаргав. Нийт 12 тайлан, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хагас болон бүтэн жилийн тайлан 2, байгууллагын ил тодын байдлыг хэрэгжилт/ сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 3 тайлан, Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн 1 тайланг ХШҮГ-т цахимаар хүргүүлсэн. Нийт 21 тайлан хүргүүлсэн<br>Хүрсэн түвшин: Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 97.9 хувийн биелэлттэй,<br>Хавсралт: 2 файл | | |
| 4.1.6 | Сайдын болон ТНБД-ын шуурхай хуралдааныг зохион байгуулах, тухай бүр үүрэг даалгаврын биелэлтийг | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Тухай бүр биелэлт гаргаж удирдлагад танилцуулсан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Удирдлагаас тогтоосон хугацаанд үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж удирдлагад | Сайдад ирсэн албан бичиг, явсан албан бичгийн хуваарилалтад хяналт тавих, тушаал шийдвэрийг албажуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж, яамны үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулж байна. Холбогдох газар, нэгж, албан хаагчдын албан бичиг, тушаал шийдвэр зохион байгуулалтыг түргэн шуурхай, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж байна. Сайдын дотоод, гадаадын зочин | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргаж, танилцуулна. | | | | танилцуулсан байна. /100 хувь/ | төлөөлөгчдийн уулзалтыг зохицуулах, хурал, зөвлөгөөний хуваарийг цаг тухай бүрд нь зохион байгуулж байна. Цаг үеийн шинжтэй яаралтай ажилд дэмжлэг үзүүлж ажилласан. Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хурал нийт 12 удаа хуралдсан үүнээс өгсөн үүрэг даалгавар хувь 92 хувьтай байна.<br>Хүрсэн түвшин: Хүлээлт 8 хувь | | |
| 4.1.7 | Мэдээллийн системүүдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн нууцлал, аюулгүй байдал болон байнгын найдвартай ажиллагааг хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Системүүд хэвийн ажилласан байх, хувиар | Тухай бүр ажилласан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Мэдээллийн системүүдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн нууцлал, аюулгүй байдал болон байнгын найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна. /100 хувь/ | Эдийн засаг, хөгжлийн яамны өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагддаг системүүдийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж, хяналт тавьж ажилласан. Яамны албан бичгийн систем /Office 365/ power automate, power apps хөгжүүлэлтүүдийг "Mogul" ХХК-ийн инженерүүд, Сангийн яамны мэдээлэл технологийн мэргэжилтнүүдтэй хамтран сайжруулалт, хөгжүүлэлт хийсэн. Office365 - Шинээр ажилд томилогдсон албан хаагч болон гэрээт зөвлөх нийт 39 хэрэглэгчийн эрх нээж өгөн, систем дээр тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсэн. ADDC - med.gov.mn домэйн удирдлага дээр шинээр ажилд томилогдсон 39 хэрэглэгчийг нэмж, ажлаас чөлөөлөгдсөн идэвхгүй байгаа хэрэглэгчдийг ангилж, идэвхгүй хэрэглэгчид цэс рүү оруулсан. Мөн Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан бүтцийн өөрчлөлтийг систем дээр хийсэн. Erp.e-mongolia.mn /Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем/. Шинээр ажилд орсон төрийн албан хаагч болон чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн албан хаагчдын | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийг тогтмол шинэчилсэн. Цаг бүртгэлийн цэсэд яамны нийт албан хаагчдыг ажлын цагийг уян хатан болгох талаар гарсан шийдвэрийн дагуу 4 төрлийн цагийн хуваарийн зохицуулалтыг систем дээр тохируулсан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/106 дугаар "Зайнаас ажиллуулах тухай" тушаалаар батлагдсан "Албан хаагчийг зайнаас ажиллуулах журам" болон " Зайнаас ажиллах боломжтой албан тушаалын жагсаалт, хуваарь"-ын дагуу тухайн албан хаагчийн хүсэлтийг газар, нэгжийн дарга нарт тухайн албан хаагч илгээн явуулах, тухайн хүсэлтийг шийдвэрлэх боломжийг тус тус газар, нэгжийн дарга нарт эрхийг нь цаг бүртгэлийн систем дээр тохируулга хийн ажилласан. Erp.e-mongolia.mn /Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем/ дээр батлагдсан бүтцийн хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамны нийт албан хаагчдын албан тушаал болон газар, хэлтсийн нэршлийг шинэчилж, засварласан.<br>Хүрсэн түвшин: 100 хувь | | |
| 4.1.8 | Гадаад, дотоод сургалтын тушаал боловсруулах, гадаад оронд сургалтад явах виз авах бичиг баримтыг холбогдох байгууллагад | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Холбогдох тушаал боловсруулж. сургалтын тайлан нэгтгэн яамны мэдээллийн цагаар тайлагнасан. | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Холбогдох тушаал боловсруулж, сургалтын тайлан нэгтгэн яамны мэдээллийн | Гадаад дотоод албан томилолтын удирдамж болон томилолтын тайлангийн загвар боловсруулж дотоод сүлжээнд байршуулсан. 2024 оны 2-р улирлаас эхлэн албан хаагчид батлагдсан загварын дагуу томилолтын удирдамж, тайлан, тушаалын төсөл боловсруулахад зөвлөгөө, шаардлагатай мэдээллээр тухай бүр хангаж ажилласан. - Гадаад албан томилолтоор ажиллах албан | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүргүүлэх, сургалтын тайланг авч нэгтгэн мэдээллийн цагийг зохион байгуулна. | | | | цагаар тайлагнасан байна. | хаагчдад баримт бичгийн бүрдүүлэлт дээр дэмжлэг үзүүлж, 31-н албан хаагчдад шинээр албан паспорт авах, 5 удаа албан паспортыг буцаан авах, БНХАУ-ын урт хугацааны тэтгэлэгт хамрагдах албан хаагчдад /3 албан хаагч/ зөвлөгөө мэдээлэл дамжуулах, материалын бүрдэл дээр хяналт хийж цуглуулах, тэтгэлэгт бүрдүүлэх материалыг ЭСЯ-д хүргэх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Түүнчлэн Гадаад улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамд руу албан хаагчдын ажлын тодорхойлолт -16, Албан ажлаар ажиллахад шаардлагатай Ноот бичиг-7 хүргүүлэх, АНУ-ын томилолттой холбоотой виз мэдүүлэг- 4, ХБНГУ-ын виз мэдүүлэг-4. - ОУВС болон Японы засгийн газартай хамтарсан хөтөлбөр болох JISPA-ийн багийн гишүүд ЭЗХЯ-ны ТЗУГ-ын даргатай уулзах хүсэлт ирүүлсний дагуу хөтөлбөрийн талаар мэдээлэл бэлтгэн удирдлагыг мэдээллээр хангаж, уулзалтад оролцсон. Холбогдох байгууллагаас мэдээлэл ирүүлэх үед танилцуулга бэлтгэн Мэдээллийн цагаар танилцуулахаар болсон. Мөн Японы улсын Засгийн газраас хэрэгжүүлдэг JDS хөтөлбөрийн талаар албан хаагчдад мэдээлэл хүргүүлэн ажилласан. - Германы засгийн газрын дэмжлэгтэй Казакстаны их сургуулийн хөтөлбөртэй холбогдож, зуны сургууль болон Ногоон эдийн засаг сэдэвт магистрын хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар санал сольцож бусад газар хэлтсүүдэд мэдээлэл хүргүүлсэн.• 2024 онд Гадаад улсад уулзалт, айлчлал, албан томилолтоор ажилласан албан хаагчдын | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
